



Монгол Улсын Их
Хурлын Тамгын газар



КОВИД 19-ТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР УЛС ОРНУУДЫН ПАРЛАМЕНТ, ЗАСГИЙН ГАЗРААС ГАРГАСАН ШИЙДВЭР, ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ

/2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар/

(Мэдээлэл, лавлагаа)
СТ-20/408

Судлаачид: Д.Бадамдаш
Г.Алтан-Оч (Ph.D.)
Г.Билгээ
Д.Жигваагүнсэл
О.Нарантуяа
Р.Нургүл
Р.Оргилмаа
Д.Халиун

Улаанбаатар
2020 он

АГУУЛГА

УДИРТГАЛ	2
1.ИБУИНВУ	6
2.АНУ	11
3.Канад	13
4.Сингапур	15
5.ОХУ	19
6.ХБНГУ	27
7.БНСУ	32
8.Итали	34
9.БНКаз.У	43
10.Япон	44
11.Бахрейн	52

УДИРТГАЛ

Судалгаанд хамрагдсан 11 улсын хувьд дийлэнх нь “КОВИД-19” вирусний тархалт өндөртэй улс орнууд байна. Эдгээр улсуудаас **Их Британи, АНУ, Канад, Сингапур** Улс нь “КОВИД-19” цар тахалтай холбоотой хууль тогтоомж баталж, **ОХУ, ХБНГУ, БНСУ** зэрэг нь 4-10 гаруй хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Италийн Үндсэн хуулийн 77-р зүйлд заасанчлан онц байдалд Засгийн газар яаралтай авах арга хэмжээний шийдвэрийг гаргах эрхийн хүрээнд 30 гаруй тогтоол, шийдвэр гаргаж, томоохон хуулиудыг Парламентаар хэлэлцүүлэн батлуулсан байна.

Японы хувьд онц байдал зарлах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор 2012 онд батлагдсан “Шинэ төрлийн ханиад, томууны эсрэг тусгай арга хэмжээ авах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, 2020.04.07-нд 7 мужид онц байдал зарласан. Засгийн газраас халдварын тархалтыг бууруулах, эдийн засгийг дэмжих холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Казахстанд коронавирусын тархалттай холбоотой Парламентаас ямар нэг тусгайлсан хууль гаргаагүй бөгөөд Засгийн газраас холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Бахрейн Улсын хувьд эдийн засгийн багц арга хэмжээний хуулийн төслийг хэлэлцэж байна.

Судалгаанд хамрагдсан улс орнуудын баталсан хууль тогтоомж, холбогдох хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг тоймолбол дараах байдалтай байна.

Их Британи Улсын хувьд Коронавирус 2020 хуулийг парламентад шуурхай буюу чуулганы 4 өдрийн дотор хэлэлцэж, 2020.03.25-ны өдөр Хатан хаан ёсорхон баталж хүчин төгөлдөр болсон. Ийнхүү дээрх баримт бичгээр Ковид-19 цар тахалтай тэмцэх зорилгоор төрийн байгууллагуудад “онцгой бүрэн эрх” олгож байгаа юм. Коронавирус 2020 хууль нь вирусний тархалтыг удаашруулахын тулд Засгийн газрын эрх хэмжээг нэмэгдүүлэх, Төрийн байгууллагын нөөц болон захиргааны ачааллыг бууруулах, Төрийн үйлчилгээ үзүүлэх явцад гарч болзошгүй хүний нөөцийн дутагдалд үзүүлэх сөрөг нөлөөг хязгаарлах гэсэн 3 үндсэн зорилготой.

Тус хуулийн зохицуулалт хийх горим нь Ковид-19 цар тахалтай тэмцэхэд нэн яаралтай, шуурхай арга хэмжээ авах боломжийг дараах байдлаар бүрдүүлж өгсөн байна. Үүнд:

- **Төсөл баталгаажуулах горим:** хүчин төгөлдөр болохоос нь өмнө парламент уг арга хэмжээг сайшаан баталсан байх шаардлагатай;
- **Нөхөн баталгаажуулах горим:** Арга хэмжээ гарсан даруй хүчин төгөлдөр хэрэгжих боловч цаашид үргэлжлэн мөрдөгдөхийн тулд парламентаар нөхөн баталгаажуулсан байх ёстой;
- **Парламентын өмнө танилцуулсан байх шаардлага:** Сайд парламентын хэлэлцүүлэггүйгээр арга хэмжээ авч хэрэгжүүлж болох авч хамгийн бодитой боломжтой хугацаанд парламентаар заавал хэлэлцүүлсэн байх шаардлагатай.

Энэхүү хуульд мөн парламентаар хэлэлцүүлэх шаардлагагүй чиглэл өгөх, зохион байгуулалт хийх, удирдамж өгөх, зааварчилгаа өгөх зэрэг бүрэн эрхийг тусгасан байна.

АНУ-ын Холбооны Засгийн газраас Covid-19 өвчний тархалт газар авч эхэлсэн үеэс нийгэм, эдийн засагт хүндрэл үүсгэхгүй байх бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байгаа бөгөөд эдийн засгийн багц арга хэмжээг яаралтай хэрэгжүүлэхээр 3 хуулийг батлаад байна. Хамгийн сүүлд буюу 2020-03-27-нд Коронавирусын үед олгох тусламж, дэмжлэг болон эдийн засгийн аюулгүй байдлын

тухай хууль (Coronavirus Aid, Relief, and Economic Security Act)¹-ийг Конгрессоос баталсан байна. Тус хуулиар Дотоодын нийт бүтээгдэхүүний 11% буюу 2.3 их наяд ам долларыг эдийн засгийн хүндрэлийг бууруулах 7 төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд зориулан баталсан байна.

Канад Улс нь Covid-19 өвчний нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж Ковид-19-ын эсрэг яаралтай арга хэмжээ авах тухай хууль (Covid-19 Emergency Response Act)-ийг баталсан байна. Тус хуулиар 2 бие даасан буюу Канадын яаралтай тусламжийн эсрэг хариу арга хэмжээ-тэтгэмжийн тухай (Canada Emergency Response Benefit Act) болон Үндэсний хэмжээний гамшиг тохиолдох олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанд хөрөнгө батлах тухай (Public Health Events of National Concern Payments Act) хуулиудыг баталж, 15 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Сингапурын хувьд тус улсын парламентаас 2020.04.07-ны өдөр “Ковид-19 түр арга хэмжээний хууль 2020”-ыг баталсан. Тус хууль нь 6 сарын хугацаанд үйлчлэх бөгөөд дахин 6 сараар сунгаж 1 жилийн хугацаанд үйлчлэх боломжтой. Энэхүү хууль нь Засгийн газар оролцож байгаа гэрээний үндсэн дээр ажил гүйцэтгэж буй аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжих зорилготой хууль юм. Тус хуулиар:

- Гэрээний үүргээ биелүүлэх төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд түр зуурын тусламж үзүүлэх;
- Санхүүгийн хувьд хүнд байдалд орсон хувь хүн, фирм болон бусад бизнесүүдэд түр зуурын тусламж үзүүлэх;
- Уулзалт, хурал зохион байгуулах түр зуурын арга хэмжээний талаар;
- Шүүх болон шариатын шүүх хуралдааны үйл ажиллагааны түр зуурын арга хэмжээ;
- Ковид-19 хяналт тавих журам зэрэг асуудлуудыг зохицуулсан байна.

ОХУ-ын хувьд 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдөр ОХУ-ын Төрийн Думээс “КОВИД-19”-ын халдварын тархалттай холбоотойгоор онц байдал, төсөв, банк, эрүүгийн хэрэг, захиргааны зөрчил, эмийн хангамжийн талаарх 10 гаруй багц хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Ингэхдээ ОХУ-ын Засгийн газарт шинэ бүрэн эрх олгох, төсвийн тодотгол яаралтай хийх, бүс нутгуудад дэмжлэг үзүүлэх, иргэд болон бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, эм хангамжид хяналт тавих, онц байдлын үед хууль тогтоомж зөрчигчдөд болон КОВИД-19”-ын худал мэдээлэл тараасан этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах зэрэг зохицуулалтууд хамрагдсан байна.

ХБНГУ-ын хувьд Парламентаас хууль, тогтоомжийн хүрээнд өөрчлөлт оруулах замаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг тоймолбол:

- Дэгийн хуульд 2020.09.30 хүртэл хугацаанд мөрдөгдөх өөрчлөлт оруулан парламентын чуулган, байнгын хорооны хурлын ирцийг 25% байхаар тогтоов, мөн шийдвэр гаргах, санал өгөхөд цахим хэрэгсэл ашиглаж болохыг зөвшөөрөв.
- Худалдааны хуульд өөрчлөлт оруулан 2020.09.30 өдөр хүртэл дампуурал зарлах үүргийг хойшлуулав.
- Халдвараас хамгаалах хуульд өөрчлөлт оруулан цар тахлын үеэр эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээг нэгдмэл байдлаар зохион байгуулах үүднээс Холбооны Улсад (өмнө нь Муж улсуудад эрх мэдэл нь байсан) холбогдох арга хэмжээ авах бүрэн эрхийг олгов. Хүүхдээ асрах эцэг буюу эхэд 6 долоо хоног хүртэл хугацаанд цалингийн гуравны хоёртой тэнцэх хэмжээний тэтгэмж олгохоор шийдвэрлэв.

¹ <https://www.congress.gov/bill/116th-congress/senate-bill/3548/text>

- Нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээ авахад тавигддаг шалгууруудыг зөөллөж, улирлын шинжтэй түр ажил эрхлэх хугацааг сунгаж, цагийн ажлын хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахгүй байхаар шийдвэрлэв.
- Эрүүгийн процессын хуульд өөрчлөлт оруулан цар тахлын үед мөрдөн байцаах ажиллагааг 100 хүртэл хоногоор завсарлаж болохоор тус тус зохицуулав.
- Хөдөлмөрийн хуульд өөрчлөлт оруулан ажлын цагийн уян хатан болгосон.

БНСУ-ын хувьд дараах хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан.

- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт;
- Хорио цээрийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт;
- Эмнэлгийн үйлчилгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт;
- Цагаачлалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт.

Итали Улсын хувьд “КОВИД-19”-ын халдварын тархалттай холбоотойгоор 2020.01.31-нд онцгой нөхцөл байдлыг улсын нутаг дэвсгэрт хэсэгчлэн зарласан. Үндсэн хуулийн 77-р зүйлд заасанчлан онцгой нөхцөл байдалд Засгийн газар яаралтай авах арга хэмжээний шийдвэрийг гаргах үүрэгтэй бөгөөд хууль ёсоор өнөөг хүртэл СнЗ-ийн ерөнхийлөгч сайд болон бүс нутгийн удирдлагуудтай зөвлөлдсөний дагуу 30 гаруй зарлиг, авах арга хэмжээний шийдвэрийг гаргаж, томоохон зарлиг-хуулийг Парламентаар хэлэлцүүлэн батлуулжээ.

Тухайлбал, Гэр бүл, ажилтнууд, ААН-үүдэд үүссэн хямралыг зохицуулах анхны зарлиг-хуулийг (СнЗ-ийн ерөнхийлөгчийн зарлиг-хууль №6)- 2020.02.23-нд баталсан. Энэ хуулиар үүссэн нөхцөл байдалд тохируулан өвчний тархалтыг бууруулах, зогсоох, хянах зэрэг бүх төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхийг холбогдох захиргаадад олгосон. Мөн шаардлагатай хөл хорио, зарим хязгаарлалтуудыг авахаас гадна ажлын цагийг багасгах, зайнаас ажиллах боломжийг бүрдүүлэх, цалин урамшуулал, татвар, зээлийн хөнгөлөлтийн арга хэмжээнүүдийг онцгой бүс нутгуудын хэмжээнд авч хэрэгжүүлэхээр зохицуулсан. Харин 2020.3.17-нд улсын хэмжээнд онц байдал зарласан, нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбогдуулан өмнө баталсан хуулийг дахин өөрчлөн 18/2020 зарлиг хуулийг баталж, өргөн хүрээнд хэрэгжүүлэхээр болсон ба санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэхээр зохицуулсан.

Казахстан Улсад коронавирусний тархалттай холбоотой парламентаас ямар нэг тусгайлсан хууль гаргаагүй бөгөөд Засгийн газраас холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Эдийн засгийг дэмжих хүрээнд иргэдийг ажлын байраар хангах, барилгын ажил эхлэх улирал ирж байгаатай холбогдуулан тус салбарын үйл ажиллагааг, мөн бусад салбаруудын үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ авсан бөгөөд ААН-үүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, зээл төлөлтийг хойшлуулах гэх арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Одоогоор Нур-Султан, Алматы хотуудад байгууллага, ААН-ийн үйл ажиллагааг түр зогсоож, Шымкент хотод хол хорио тогтоосон байна. Эдгээр хотуудад түргэн хугацаанд хурдан баригдах технологи ашиглан халдварт өвчний эмнэлэг байгуулах шийдвэр гаргасан.

Тус улсын эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд коронавирусний халдварыг тодорхойлох тестийг гарган авсан байна.

Коронавирусний өвчлөлтэй тэмцэж буй эрүүл мэндийн ажилтнуудад нэмэгдэл хөлс, тэтгэмж олгох, нөхцөл байдлын улмаас ажилгүй болсон иргэдэд тэтгэмж олгох, нийгмийн эмзэг бүлгийнхэнд үнэгүй хүнсний бүтээгдэхүүн өгөх болон бусад нэн шаардлагатай арга хэмжээ авч ажиллаж байна.

Дээрх арга хэмжээнүүдтэй холбоотой иргэн, ААН нь холбогдох бичиг баримтыг бүрдүүлж өгөх шаардлагагүй бөгөөд хүсэлтийг цахимаар хүлээж авахаар зохион байгуулж байна.

Казахстан улсын Ерөнхийлөгчийн Онц байдал зарлах тухай зарлигийн хүрээнд 2020 оны 4-р сарын 1-нд “Казахстан улсын иргэдийн аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай” Эрүүл мэндийг хамгаалах яам, Бараа бүтээгдэхүүн болон

үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хороо, Улсын ерөнхий эрүүл ахуйч эмч хамтарсан тогтоол баталсан.

Япон Улсын хувьд онц байдал зарлах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор 2012 онд батлагдсан “Шинэ төрлийн ханиад, томууны эсрэг тусгай арга хэмжээ авах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, 2020.03.14-ны өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн. Улмаар 2020.04.07-нд Японы Ерөнхий сайд Шинзо Абе нийт 7 префектур (муж)-д онц байдал зарласан.

Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь Ковид-19 халдварын үзлэг, оношилгоо, эрсдэлт бүлэг болох ахмад настан болон хүүхдүүдийг халдвараас хамгаалахад сургуулийн үйл ажиллагааг түр зогсоох зэрэг арга хэмжээнүүд дээр төвлөрч байна.

Эдийн засгийн багц арга хэмжээнүүд (төсвийн арга хэмжээ: ойролцоогоор 400 тэрбум иен; санхүүгийн арга хэмжээ: нийт 1.6 их наяд иен) дээр дурдсан хүрээнд халдварыг үзлэг, оношилгооны хүчин чадлыг нэмэгдүүлэх, яаралтай тусламж, эмчилгээний боломж бололцоог дээшлүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж, хамгаалалт, ариутгалын хэрэгслээр хангах, сургуулийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотойгоор эцэх, эхчүүдэд ажлын чөлөө олгоход дэмжлэг үзүүлэх, орлого нь буурсан өрхүүдэд 100,000-200,000 иен хүртэлх хүүгүй зээл олгох, хичээлээс гадуурх арга хэмжээг санхүүжүүлэх, нялх хүүхэд асрах үйлчилгээний хөнгөлөлтийг нэмэгдүүлэх, сургуулийн үдийн хоолны төлбөрийг эцэг, эхчүүдэд буцаан олгох, сургуулийн хоол үйлдвэрлэгч, нийлүүлэгч нарт зохих дэмжлэг үзүүлэх зэрэг хөнгөлөлт, дэмжлэг үзүүлнэ.

Бизнес эрхлэгч, ажлын байр хадгалахтай холбоотой татаас, дэмжлэг, хөнгөлөлтүүд нь гол төлөв бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч нарт чиглэгдэж байна.

--ooOoo--

1.ИБУИНВУ

Coronavirus Act 2020 – Коронавирус 2020 хууль

Хураангуй танилцуулга²

Коронавирус 2020 хуулийг парламентад шуурхай буюу чуулганы 4 өдрийн дотор хэлэлцэж, 3 сарын 25-ны өдөр Хатан хаан ёсорхон баталж хүчин төгөлдөр болов. Энэхүү тогтоолоор Ковид 19 цар тахалтай тэмцэх зорилгоор төрийн байгууллагуудад “Онцгой бүрэн эрх” олгож байгаа юм.

Энэхүү тогтоомж нь дараах 3 үндсэн зорилготой:

Вирусний тархалтыг удаашруулахын тулд Засгийн газрын эрх хэмжээг нэмэгдүүлэх,

Төрийн байгууллагын нөөц болон захиргааны ачааллыг бууруулах,

Төрийн үйлчилгээ үзүүлэх явцад гарч болзошгүй хүний нөөцийн дутагдалд үзүүлэх сөрөг нөлөөг хязгаарлах зэрэг болно.

Үндсэн сэдэв	Гол заалт	Гол утга
Үйлчилгээнд ажиллаж буй ажиллагсдын ачааллыг хөнгөвчлөх, албан хаагчдын дутагдалд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах	2–9	Үндэсний эрүүлийг хамгаалах тогтолцооны хүний нөөцийн дутагдлыг бууруулах Саяхан тэтгэвэртээ гарсан эрүүл мэнд, нийгмийн хамгааллын ажилтнууд, төгсөх курсын анагаахын салбарын оюутнууд, мөн саяхан энэ салбар ажлаас гарсан байгаа хүмүүсийг ажилд бүртгэхийг зөвшөөрсөн. Тэтгэвэртээ гарсан боловч эргээд Эрүүл мэндийн тогтолцоонд ажиллаж буй албан хаагчдад тавигдах ажлын цагийн хязгаарлалтыг түдгэлзүүлэв. Эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт ажилладаг сайн дурын ажилтнуудыг Нэгдсэн вант улсын нөхөн төлбөрийн сангаас тэтгэмжтэйгээр цалингүй чөлөө авахыг зөвшөөрөв. Мөн уг хуулиар онцгой байдлын үеийн сайн дурын ажилтнуудыг ажиллуулах тухай тусгав.
	10; 14–17	Эрүүлийг хамгаалах тогтолцоо ба орон нутгийн нөөцөд тулгамдаж буй дарамтыг хөнгөвчлөх Мөнхүү хууль эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад эмнэлгээс гарахаас өмнө өвчтөний эмчилгээний явцыг үнэлгээг хойшлуулахыг зөвшөөрөв. Мөн орон нутгийн удирдлагын зүгээс онцгой тохиолдолд насанд хүрсэн иргэд асаргаа, дэмжлэг шаардлагатай гэж үзэж “хэрэгцээний үнэлгээ” хийхэд тавигдах шаардлагыг хялбарчлав. Мөн уг хуулиар эрүүл мэндийн цөөн мэргэжилтний дүгнэлтэд тулгуурлан сэтгэцийн эрүүл мэндийн өвчтөнийг саатуулж, эмчлэх эрхийг олгов.
	18–21, 30–32	Иргэдэд шууд үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудын захиргааны ачааллыг бууруулав Уг хуулиар нас барсан, амьгүй төрөлтийг бүртгэх, гэрчилгээ олгох болон чандарлах зөвшөөрлийг олгох зохицуулалтыг хялбаршуулав.

² The Institute for Government. “What does the Coronavirus Act Say?” accessed on April 7, 2020 at <https://www.instituteforgovernment.org.uk/explainers/coronavirus-act>

³ Coronavirus Act 2020 (342 pages) accessed at on April 7, 2020: <http://www.legislation.gov.uk/ukpga/2020/7/enacted/data.pdf>

		Уг хуулиар хэрэв ковид тахлаас болж нас барсан тохиолдолд мөрдөн байцаалтыг Англи, Уэльс, Умард Ирландын шүүхээр явуулах шаардлагыг хүчингүй болгов (хуулиар бусад онцгой өвчний шалтгааныг ч мөн ингэж тогтоодог).
11–13	Алдагдал хохирлоос хамгаалах баталгаа	Уг хуулиар төв засгийн сайд нар болон эрх мэдэл шилжсэн нутгийн удирдах байгууллагын сайд нар Эрүүлийг хамгаалах тогтолцооны үйл ажиллагааны явцад үүсэх эрүүл мэндийн сэрэмжгүй байдлаас үүсэх хариуцлагын хохирлыг хариуцахаар болгов.
58	Цогцос хадгалалт	Холбогдох байгууллага, орон нутгийн удирдлага холбогдох байгууллагуудаас цогцос тээвэрлэх, хадгалах зэрэг үйлчилгээ үзүүлдэг зориулалт байр, тээвэрлэлт, үйлчилгээ үзүүлэх чадамжийг бүрэн хангаж ажиллахыг шаардах бүрэн эрхийг тусгав.
22–23	Мөрдөн шалгах эрх мэдлийн тухай хуульд заагдсан шаардлагыг өөрчлөх	Мөрдөн шалгах хуулийн дагуу баривчлах зөвшөөрөлд төрийн сайд болон шүүхийн 15 комиссарын нэг нь хамтын гарын үсэг зурдаг. Ковид-19 тахлын улмаас комиссаруудын хүрэлцээ хангалтгүй байх магадлалтай тул шүүхийн нэмэлт комиссаруудыг түр хугацаанд томилох, мөн томилгооны үйл явцад мөн өөрчлөлт оруулав. Ихэвчлэн, шүүхийн комиссарууд баривчлах зөвшөөрлийг уг баривчилгаа хийгдсэний дараа 3 хоногийн дотор сүүлд гарын үсэг зурдаг. Комиссаруудад очих ачааллыг хөнгөвчлөхийн тулд энэ хугацааг 12 хүртэл хоног сунгахыг зөвшөөрөв. Баривчлах зөвшөөрөл дээд тал нь 5 хоногийн хугацаанд хүчинтэй байдаг. Энэхүү хуулиар энэ хугацааг 12 хүртэл хоног болгож сунгав.
24	Хурууны хээ болон ДНХ мэдээллийг хадгалах хугацаан сунгах	Уг хуулиар төрийн сайд ковид халдвар үндэсний аюулгүй байдлын шийдвэр гаргагчдын чадамжид сөрөг нөлөөтэй, нөлөө үзүүлж болзошгүй, эсвэл үндэсний аюулгүй байдлын үүднээс шаардлагатай гэж үзвэл Засгийн газар хурууны хээ, ДНХ мэдээллийг хадгалах хугацааг 6 сар хүртэл сунгахыг зөвшөөрөв.
Вирусын тархалыг удаашруулах, хязгаарлах	50	Боомтын үйл ажиллагааг түр зогсоох Энэхүү хуулиар хил хамгаалах Хилийн хүчний албан хаагчид дутагдалтай гэж үзвэл боомтын үйл ажиллагааг зогсоох эрхийг олгов. Боомтын үйл ажиллагааг зогсоох шийдвэрийг Сайдын нэрийн өмнөөс Хилийн хүчний удирдах албан тушаалтан гаргана. Харин боомтын үйл ажиллагааг 12 цагаас илүү хугацаанд зогсоох бол сайд нарын шийдвэрээр зогсооно.
	51	Халдвар тээж болзошгүй хүний талаарх эрх мэдэл Аливаа хүнийг халдвар авсан байж болзошгүй гэж үзэх хангалттай үндэслэлтэй гэж үзвэл тухайн хүнээс сорил авах, тусгаарлах, саатуулах онцгой бүрэн эрхийг Английн төрийн албан хаагчдад олгосон шийдвэрийг Засгийн газар гаргасан билээ. Энэхүү шийдвэрийг уг хуулиар хуульчлан баталгаажуулж, үйлчлэх нутаг дэвсгэрийн хувьд бүх Нэгдсэн вант улсын хэмжээнд үйлчлэхээр заав.

		Энэхүү олгосон эрх мэдлийг зөрчсөн бол гэмт хэрэг гэж үзэх бөгөөд зөрчсөн этгээдэд торгууль ногдуулна.
	52	Олон нийтийн цуглаан, байгууламжийн талаарх эрх мэдэл Энэхүү хуулиар төрийн сайд болон эрх мэдэл шилжсэн нутгийн захиргааны сайд нарт олон нийтийг хамарсан цуглаан, арга хэмжээ явуулахыг хязгаарлах, хориглох, олон нийтийн байгууламжид орохыг хязгаарлах, хаах зэрэг шийдвэр гаргах эрхийг өгсөн. Вирусний тархалт нь олон нийтийн эрүүл мэндэд “ноцтой бөгөөд илэрхий” аюул занал учруулахаар байгаа тухай албан ёсны тунхаглал гаргасан, эсвэл ингэж хязгаарлах нь вирусын халдварыг хязгаарлах болон эрүүл мэндийн болон онцгой байдлын нөөцийг хамгийн оновчтой хуваарилах, байршуулахад шаардлагатай гэж үзвэл сайд энэхүү эрхийг хэрэгжүүлж болно. Энэхүү олгосон эрх мэдлийг зөрчсөн бол гэмт хэрэг гэж үзэх бөгөөд зөрчсөн этгээдэд торгууль ногдуулна.
	36	Шотланд дахь вакцинжуулалт Өнөөгийн байдлаар Шотландад эрүүл мэндийн албан хаагчид болон тэдний хяналтд доор ажиллагсад вакцинжуулалт хийдэг. Уг хуулиар эрүүл мэндийн илүү олон мэргэжилтнүүд вакцинжуулалт хийхийг зөвшөөрч байна.
	37–38	Сургууль/хүүхдийн халамжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд Энэхүү хуулиар сайд нарт сургууль болон бүртгэгдсэн хүүхдийн халамжийн газруудыг түр зогсоох шийдвэр гаргах эрхийг олгов.Ийнхүү сайд шийдвэр гаргасан тохиолдолд тухайн байгууллага заагдсан тодорхой хугацаанд хүмүүс тус байгууламжид ирэхийг зогсоох зохих арга хэмжээ авсан байх ёстой. Мөн сайд тодорхой байгууламжийн хэсэг болон хүмүүсийн тухай илүү нарийвчилсан чиглэл заасан шийдвэр гаргаж болно. Энэхүү эрх мэдлээ хэрэгжүүлэхийн өмнө сайд нар олон нийтийн эрүүл мэндийн чиглэлийн албан хаагчдаас зохих зөвлөгөө авсан байх ёстой.
	53–57	Шүүх дээрх технологи Энэхүү хуулиар шүүхийн байцаан шийдвэрлэх үйл явцад холбогдох талууд болон гэрчийн этгээдүүд биеэр хүрэлцэн ирэхгүйгээр цахимаар оролцох заалтуудыг оруулж өгсөн болно. Мөн хэрэв үйл ажиллагааны хязгаарлаж буй тухай Засгийн газрын шийдвэрийг давж заалдан магистратын шүүхэд хандаж байгаа бол цахим линкээр оролцохыг зааж өгсөн юм.
Эдийн засгийн дэмжлэг	39–44	Хууль ёсны өвчний чөлөөний цалин Ажилтнуудын Ковид 19 тахалтай холбоотой чөлөөтэй байх үеийн цалингийн нөхөн олговрыг зарим ажил олгогчид Хатан хааны орлого, гаалийн газраас нэхэмжлэх зохицуулалтыг оруулж өгөв. Мөн энэхүү өвчний чөлөөний цалингийн олговрыг өвчний 4 дэх өдрөөс бус эхний өдрөөс олгодог болохоор өөрчлөв. Засгийн газар энэхүү өөрчлөлт нь ажилчид халдвар авсан ч гэртээ байгаад байх нөхцөлөөс урьдчилан сэргийлнэ гэж үзсэн юм.
	45–47	Тэтгэвэр

		Эрүүл мэндийн салбараас тэтгэвэр авагчид эргэж ажлаа хийхэд тавигддаг хориог цуцлах юм. Энэ нь эрүүл мэндийн салбар ажиллаж байгаад тэтгэвэртээ гарсан хүмүүс буцаж ажлаа хийхэд учрах саад бэрхшээлийг арилгаж байгаа гэж үзэж байгаа юм.
	72–74	Үндэсний даатгалын төлбөр Уг хуулиар Үндэсний даатгалын төлбөрийн өөрчлөгдөх түвшинд тавигдах шаардлагыг түр хугацаагаар хөнгөвчлөх
	81–83	Түрээслэгчдийг хамгаалах нь Орон сууц түрээслэгчдийг – байрнаас хөөхөөс хамгаалах: Орон сууцанд амьдардаг хүмүүсийн хувьд ихэнх түрээслэгчдийг байраа суллаж өгөх мэдэгдлийн жишиг хугацаа 2 сар байгааг 3 сар хүртэл сунгах Бизнес түрээслэгч – гэрээ зөрчсөн хариуцлагаас хамгаалах: Засгийн газраас түрээсээ хугацаандаа төлж амжаагүйд хариуцлага хүлээлгэх, үл хөдлөх хөрөнгийг буцааж авах үйл ажиллагааг түр хугацаанд хязгаарлах шийдвэрийг Нийтийн танхимд танилцуулсан.
	25–29	Хүнсний хангамж Засгийн газраас хүнсний ханган нийлүүлэгч, жишиглэн худалдаа эрхлэгчдийг хүнсний хангамжийн талаар мэдээллээр хангахыг шаардах эрхийг уг хуулиар олгосон.
Сонгууль хойшлуулах (see our explainer)	59	2020 оны 5 сарын сонгууль Уг хуулиар орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд, орон нутгийн мэр, цагдаагийн комиссарууд, Лондон хотын мэр, Лондонгийн чуулганы сонгуулийг 2021 оны 5 сар хүртэл хойшлуулав.
	60	Бүрэн эрхийн хугацаа 2021 онд сонгогдох Орон нутгийн иргэдийн хурал, мэрүүд, Лондонгийн чуулганы гишүүд, цагдаагийн комиссаруудыг 4 биш 3 жилийн хугацаатай сонгож ажиллуулахыг зааж өгсөн.
	61–70	Бусад сонгуулиуд Уг хуулиар орон нутгийн, Вестминстерийн болон эрх шилжсэн засаг захиргааны хууль тогтоох байгууллагуудын нөхөн сонгуулиудыг 2021 оны 5 сар хүртэл хойшлуулав.
Эрх мэдлийг хэрэгжүүлэх ба парламентын хяналт	87	Хуулийн заалтууд хүчин төгөлдөр болох нь Хуулийн зарим заалтууд (эрүүл мэндийн ажилтнуудыг онцгой байдлын нөхцөлд бүртгэх) нь Хатан хаан ёсорхон баталмагц хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Бусад заалтууд тухайлан онцгой байдлын үеийн сайн дурынхан, сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой өөрчлөлт, хүнсний хангамжийн тухай заалтууд нь Нэгдсэн вант улсын сайд (буюу зарим тохиолдолд эрх шилжсэн захиргааны сайд) эдгээр заалтыг хүчин төгөлдөр мөрдөх зохицуулалт гаргана.
	88	Дээрх заалтуудыг хэрэгжүүлэх болон зогсоох бүрэн эрх Нэгдсэн вант улсын сайд (буюу зарим тохиолдолд эрх шилжсэн захиргааны сайд) энэхүү хуулийн зарим заалтыг хэрэгцээнээс хамааран хэрэглэх эсэхийг шийдэх эрхтэй. Сайд нар эрхлэх асуудлын хүрээнд өөр өөр зохицуулалт гаргах боломжтой. Харин олон арга хэмжээний хувьд тухайлан халдвар тээж болзошгүй

	<p>хүмүүс болон олон нийтийн арга хэмжээг хязгаарлах зэрэг арга хэмжээнүүд нэг мөрдсөн бол буцаах боломжгүй арга хэмжээнүүд юм.</p>
89 and 98	<p>Эдгээр арга хэмжээ хэр удаан үргэлжлэх вэ</p> <p>Уг хуулийн ихэнх заалтууд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 2 жилийн дараа хүчингүй болно. Харин зарим заалтууд тухайлан эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг онцгой байдлын үеийн бүртгэл хийж ажиллуулах болон эрүүл мэндийн үйл ажиллагаанаас учрах хохирлыг барагдуулах зэрэг нь хоёр жилээр хязгаарлагдахгүй үйлчлэлтэй юм.</p> <p>Парламентын гишүүд уг хуулийн түр заалтын хэрэгжилтийн явцын талаар 6 сар тутам санал бодлоо илэрхийлэх боломжтой байх юм. Холбогдох асуудлаар сайд нар тухайн хуулийн холбогдох заалтууд хүчинтэй хэвээр байх эсэхэд боломжтой бол 6 сар тутамд санал асуулга явуулж шийдэж байна. Хэрэв парламентын гишүүд санал хураах боломжтой байгаад уг хуулийн заалтуудыг үргэлжлүүлэхийн эсрэг санал өгвөл, Засгийн газар 21 хоногийн дотор заалтуудыг хэрэгжилтийг хүчингүй болгох зохицуулалт хийх ёстой. Хэрэв парламентын чуулган хугацаанд л Парламентын гишүүд эрх мэдлийг үргэлжлүүлэх эсэхэд л санал хураах боломжтой юм. Харин чуулганы завсарлагааны үеэр бол энэхүү эрх мэдэл хэвээр үргэлжлэх юм.</p>
90	<p>Хуулийн хүчин төгөлдөр хэрэгжиж дуусгавар болох хугацааг өөрчлөх бүрэн эрх</p> <p>Нэгдсэн вант улсын сайд (буюу зарим тохиолдолд эрх шилжсэн захиргааны сайд) шаардлагатай тохиолдолд хуулийн зарим заалтын хэрэгжих хугацааг 2 жилээс илүү сунган тогтоож болно. (дээд тал нь 6 сараар). Энэ хугацааг мөн багасгаж болно.</p>
97	<p>Хуулийн хэрэгжилтийн талаарх тайлан</p> <p>Мөнхүү хуулиар Засгийн газар хуулийн эрх мэдэл төлөөлүүлж, шилжүүлээгүй заалтуудын хэрэгжилтийн талаарх тайланг 2 сар тутам хэвлэн нийтэлж байна. Тайланг өгөх хугацаанд Парламентын чуулган завсарласан байвал уг тайлан Засгийн газрын вебсайт гэх зэрэг газар нийтэлнэ.</p>
99	<p>Уг хуулийн эрх мэдэл төлөөлүүлээгүй, шилжүүлээгүй хэсгүүдээр парламент нэг жилийн дараа хэлэлцүүлэг хийнэ</p> <p>Хатан хаан ёсорхон баталснаас хойш 1 жилийн дараа Парламентын хоёр танхим уг хуулийн талаар хэлэлцүүлэг хийнэ. (өөрөөр хэлбэл уг хуулийн гол заалтууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байх үед). Хэрэв чуулганы завсарлагаан таарвал, чуулган эхэлснээс хойших эхний 14 хоногийн дотор уг хэлэлцүүлгийг зохион байгуулна.</p>
Зохицуулалт хийх горим	<p>Уг хуулийн эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл явцад дараах түвшний хяналт тавина. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төсөл баталгаажуулах горим: хүчин төгөлдөр болохоос нь өмнө парламент уг арга хэмжээг сайшаан баталсан байх шаардлагатай • Нөхөн баталгаажуулах горим: Арга хэмжээ гарсан даруй хүчин төгөлдөр хэрэгжих боловч цаашид үргэлжлэн мөрдөгдөхийн тулд парламентаар нөхөн баталгаажуулсан байх ёстой.

- **Парламентын өмнө танилцуулсан байх шаардлага:** сайд парламентын хэлэлцүүлэггүйгээр арга хэмжээ авч хэрэгжүүлж болох авч хамгийн бодитой боломжтой хугацаанд парламентаар заавал хэлэлцүүлсэн байх шаардлагатай.

Энэхүү хуульд мөн парламентаар хэлэлцүүлэх шаардлагагүй чиглэл өгөх, зохион байгуулалт хийх, удирдамж өгөх, зааварчилгаа өгөх зэрэг бүрэн эрхийг тусгасан байна.

Товчлон орчуулсан Д.Бадамдаш УИХТГ, ПСХ 2020.04.07

2.АНУ

Эх сурвалж:

- <https://www.worldometers.info/coronavirus/country/us/>
- https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/cases-updates/cases-in-us.html?CDC_AA_refVal=https%3A%2F%2Fwww.cdc.gov%2Fcoronavirus%2F2019-ncov%2Fcases-in-us.html
- <https://www.usa.gov/coronavirus>
- <https://www.congress.gov/bill/116th-congress/house-bill/6074>
- <https://www.whitehouse.gov/briefings-statements/remarks-president-trump-address-nation/>

АНУ	
Нөхцөл байдал	2020.04.10-ны байдлаар Covid-19 шинэ төрлийн коронавирусын халдварын 468895 тохиолдол бүртгэгдээд байгаагаас 16697 хүн нас барж, 25928 хүн эдгэрсэн байна. ⁴ Халдвар орон даяар бүх мужуудад тархсан байна ⁵
Хууль тогтоомжийн чиглэлээр:	2020.03.27-нд Коронавирусын үед олгох тусламж, дэмжлэг болон эдийн засгийн аюулгүй байдлын тухай хууль (Coronavirus Aid, Relief, and Economic Security Act) ⁶ -ийг Конгрессоос баталсан байна. Тус хуулиар ажил олгогчийн татвар, тэтгэвэртэй холбоотой асуудлууд, цалинтай чөлөө, ажилгүйдлийн даатгал болон хувь хүмүүст бэлнээр олгох нэг удаагийн тэтгэмжийн талаар зохицуулсан байна. Тус хуулиар баталсан 2.3 их наяд ам доллар (ойролцоогоор ДНБ-ий 11%)-ын тусламжийг дараах зүйлүүдэд зарцуулахаар шийдвэрлэсэн байна. Үүнд: 1. 250 тэрбум ам долларыг хувь хүмүүст нэг удаагийн татварын хөнгөлөлт үзүүлэхэд; 2. 250 тэрбум ам долларыг ажилгүйдлийн тэтгэмжийг нэмэгдүүлэхэд;

⁴ <https://www.worldometers.info/coronavirus/country/us/>

⁵ https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/cases-updates/cases-in-us.html?CDC_AA_refVal=https%3A%2F%2Fwww.cdc.gov%2Fcoronavirus%2F2019-ncov%2Fcases-in-us.html

⁶ <https://www.congress.gov/bill/116th-congress/senate-bill/3548/text>

-
3. 24 тэрбум ам долларыг эмзэг бүлгийн иргэдэд хоол хүнсний тусламж олгоход;
 4. 510 тэрбум ам долларыг зээл олгож, батлан дааж, Холбооны нөөцийн хөтөлбөрийг дэмжин ажилласнаар корпорациудыг дампуурахаас сэргийлэхэд;
 5. 349 тэрбум ам долларыг өнөөг хүртэл ажилчдаа харж хандсаар байгаа жижиг бизнес эрхлэгчдэд зээл олгох, баталгаа гаргахад нь зориулж Жижиг бизнес эрхлэгчдийн газарт олгоход;
 6. 100 тэрбум ам долларыг эмнэлгүүдэд;
 7. 150 тэрбум ам долларыг мужийн болон орон нутгийн засаг захиргаанд яаралтай арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд тус тус шийдвэрлэсэн байна.⁷

2020.03-18-нд

“Коронавирусын хариу арга хэмжээ-гэр бүлүүдийг тэргүүн ээлжинд хамгаалах тухай” (Families first coronavirus response act) хуулийг Конгрессоос баталсан байна. Тус хуулиар **104 тэрбум ам долларыг** дараах арга хэмжээнүүдэд зориулан баталсан байна:

- Covid-19 өвчний улмаас ажиллах боломжгүй болсон ажилчдад цалинтай чөлөө олгоход;
- коронавирусыг үнэгүй оношлох;
- хүнсний тусламжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх;
- эрүүлийг хамгаалах ажилтнуудыг хамгаалах талаар нэмэлт арга хэмжээ авах зэрэг болно.

2020.03.06-нд **“Коронавирустай тэмцэх, хариу арга хэмжээ авахад нэмэлт төсөв батлах тухай”** (Coronavirus Preparedness and Response Supplemental Appropriations Act, 2020)⁸ хуулийг Конгрессоос баталсан байна. Тус хуулиар коронавирусний дэгдэлтийн эсрэг хариу арга хэмжээ авахад зориулж холбооны агентлагуудад **8.3 тэрбум ам долларын яаралтай тусламж** олгохоор шийдвэрлэжээ.

Дээрх тусламжийн хөрөнгийг дараах арга хэмжээнүүдэд зарцуулна. Үүнд:

- Вакцин болон шаардлагатай бусад эмнэлгийн хэрэгслүүдийг боловсруулах, үйлдвэрлэх болон худалдан авахад
- Улсын болон орон нутгийн эрүүл мэндийн агентлаг болон байгууллагуудад тусламж олгоход
- Өвчний тархалтын нөлөөнд өртсөн жижиг бизнес эрхлэгчдэд зээл олгоход
- АНУ-ын ЭСЯамд болон Төрийн департаментын барилга байгууламжуудаас нүүлгэн шилжүүлэлт хийх болон бусад яаралтай бэлтгэл үйл ажиллагааг зохион байгуулахад
- Өвчин дэлгэрсэн бусад улс орнуудын эрүүл мэндийн байгууллагуудад хүмүүнлэгийн тусламж үзүүлэхэд зэрэг болно.

2020.03-20-нд

⁷ https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19?fbclid=IwAR0s3AHnfC2wAk_-dMLMFdAMRIXtFGaVQz7Z0Rh6IkXv8eWPTBvr-xCdjxE

⁸ <https://www.congress.gov/bill/116th-congress/house-bill/6074>

Сангийн яамнаас Татвар төлөх өдрийг 2020-04-15-аас 2020-07-15 хүртэл хойшлуулсан байна. Энэ хугацаанд нийт татвар төлөгчдөд татвар төлөөгүй хугацаанд нэмэлт хүү тооцохгүй, торгууль ногдуулахгүй гэж мэдэгдсэн байна. Харин татварын буцаан олголтоо авч болох бөгөөд хүсэлт гаргасан иргэний асуудлыг яаралтай шийдвэрлэх болно гэж мэдэгдэв.

3.Канад

Канад	
Нөхцөл байдал	2020.04.09-ний байдлаар Covid-19 шинэ төрлийн коронавирусын халдварын 20765 тохиолдол бүртгэгдээд байгаагаас 509 хүн нас барж, 5311 хүн эдгэрсэн байна. ⁹
Хууль тогтоомжийн чиглэлээр:¹⁰	<p>2020.03.25-нд</p> <p>Ковид-19-ын эсрэг яаралтай арга хэмжээ авах тухай хууль (Covid-19 Emergency Response Act)-ийг баталсан байна.¹¹</p> <p>Хэсэг 1. Covid-19 өвчний эсрэг хариу арга хэмжээний нэг хэсэг болгон тодорхой орлогын татварын талаар авах арга хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> a. GST/HST татварын хөнгөлөлтийн дагуу нэг удаагийн нэмэлт төлбөрийг хийх; b. Канадын Хүүхдийн Тэтгэмжид түр хугацааны нэмэгдлийг нэмж батлах; d. Жижиг бизнес эрхлэгч, ажил олгогчдод гурван сарын хугацаанд цалингийн тэтгэмж олгох. <p>Хэсэг 2.Канадын яаралтай тусламжийн эсрэг хариу арга хэмжээ-тэтгэмжийн тухай хууль (Canada Emergency Response Benefit Act)-ийг баталж коронавирусын тархалтын улмаас орлогогүй болсон ажилчдад орлогыг дэмжих тэтгэмж олгохыг зөвшөөрөх.</p> <p>Хэсэг 3. Үндэсний хэмжээний гамшиг тохиолдоход олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанд хөрөнгө батлах тухай хууль (Public Health Events of National Concern Payments Act)-ийг баталж шаардлагатай хөрөнгийг Орлогын нэгдсэн сангаас гаргаж байх.</p> <p>Хэсэг 4. Канадын хадгаламжийн даатгалын корпорацийн тухай хууль (Canada Deposit Insurance Corporation Act)-д Сангийн сайдад хадгаламжийн даатгалын хэмжээг 2020-09-30 хүртэл нэмэгдүүлэхийг зөвшөөрсөн нэмэлтийг оруулах.</p> <p>Хэсэг 5. Канадын Моргөж болон Орон сууцны Корпорацийн тухай хууль (Canada Mortgage and Housing Corporation Act)-д тус корпорацийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор Орлогын нэгдсэн сангаас тэтгэмж олгохыг Сангийн сайдад зөвшөөрөх тухай нэмэлт оруулах.</p>

⁹ <https://www.worldometers.info/coronavirus/country/canada/>

¹⁰ <https://www.justice.gc.ca/eng/csj-sjc/covid.html>

¹¹ https://laws-lois.justice.gc.ca/eng/AnnualStatutes/2020_5/page-1.html

Хэсэг 6. Экспортыг хөгжүүлэх тухай хууль (Export Development Act)-д Канадын экспортыг хөгжүүлэхэд чиглэсэн зорилтыг өргөжүүлэх, 2020-09-30 хүртэл Сангийн сайдад Экспортыг хөгжүүлэхээр батлагдсан хөрөнгийн хэмжээ болон тодорхой хязгаарлалтын хэмжээг дахин тогтоохыг үүрэг болгох тухай болон бусад нэмэлтийг оруулах.

Хэсэг 7. Холбооны болон Бүсийн хэмжээн дэх санхүүгийн зохицуулалтын тухай хууль (Federal-Provincial Fiscal Arrangements Act)-д аймаг, бүс нутгуудын 2019-04-01-ээс эхэлсэн санхүүгийн жилийн төсөв дээр нэмэлт төсвийг батлах тухай нэмэлтийг оруулах.

Хэсэг 8. Санхүүгийн удирдлагын тухай хууль (Financial Administration Act)-д Сангийн сайдад Канад улсын санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах тодорхой үйл ажиллагаа явуулахыг 2020-09-30 хүртэл зөвшөөрөх тухай нэмэлтийг оруулах. Үүнтэй холбоотой Зээлэх эрхийн тухай хууль (Borrowing Authority Act) болон Канадын хадгаламжийн даатгалын корпорацын тухай хууль (Canada Deposit Insurance Corporation Act)-д тодорхой нэмэлт өөрчлөлтүүдийг хийх.

Хэсэг 9. Хоол хүнс болон эмийн тухай хууль (Food and Drugs Act)-д иргэдийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс эм, эмнэлгийн хэрэгслийн хомсдлоос сэргийлэх зорилготой захирамж гаргаж ажиллахыг Зөвлөлийн захирагчид зөвшөөрөх тухай нэмэлтийг оруулах.

Хэсэг 10. Канадын Хөдөлмөрийн тухай хууль (Canada Labour Code)-д ажилтанд Covid-19 өвчинтэй холбоотой 16 долоо хоног хүртэл хугацааны чөлөө олгох, болон энэ заалтыг хүчингүй болгох тухай заалтыг хуульд оруулах, түүнчлэн эрүүл мэндийн шалтгааны улмаас олгох чөлөөний тухай заалтад хөл хорионы үеийн чөлөөний тухай нэмэлтийг тус тус оруулах.

Хэсэг 12. Патентын тухай хууль (Patent Act)-д Бүрэн эрхэт төлөөлөгч нь Эрүүл мэндийн сайдын мэдэгдлийн дагуу, тус мэдэгдэлд дурдсанаар Канадын Засгийн газар болон дурдагдсан иргэний олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор патент олгосон бүтээгдэхүүнийг хийх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах эрх олгох тухай нэмэлт оруулах.

Хэсэг 13. Канадын Оюутны зээлийн тухай хууль (Canada Student Loan Act)-д 2020-03-30-аас 2020-09-30-ныг хүртэл батлан даалт бүхий оюутны зээлд хүү тооцохгүй байх гэх мэт нэмэгдлүүдийг оруулах.

Хэсэг 14. Ферм эрхлэгчдэд олгох зээлийн тухай хууль (Farm Credit Canada Act)-д Канадын ферм эрхлэгчдийн холбоонд Орлогын үндэсний сангаас тэтгэмж олгохыг Сангийн сайдад зөвшөөрөх тухай нэмэлтийг оруулах.

Хэсэг 15. Канадын оюутны санхүүгийн тусламжийн тухай хууль (Canada Student Financial Assistance Act)-д 2020-03-30-аас 2020-09-30-ныг хүртэл оюутны зээл авсан зээлдэгчид зээлийн хүү тооцохгүй байх тухай нэмэлтийг оруулах.

Хэсэг 16. Канадын бизнесийн хөгжлийн банкны тухай хууль (Business Development Bank of Canada Act)-д Сангийн сайдад Бизнесийн хөгжлийн банктай холбоотой тодорхой асуудлыг шийдвэрлэх эрхийг олгох тухай нэмэлт оруулах.

Хэсэг 17. Дагалдан сурагчийн зээлийн тухай хууль (Apprentice Loans Act)-д 2020-03-30-аас 2020-09-30-ныг хүртэл дагалдан сурагчийн зээлд хүү тооцохгүй байх тухай нэмэлтийг оруулах.

Хэсэг 18. Ажил эрхлэлтийн даатгалын тухай хууль (Employment Insurance Act)-д Хөдөлмөр, нийгмийн хөгжлийн сайдад Covid-19 өвчнөөс улбаатай эдийн засгийн нөлөөг бууруулах түр арга хэмжээ авах эрхийг олгох тухай нэмэлт оруулахаар шийдвэрлэсэн байна.

2020.03.13-нд

Санхүүгийн удирдлагын тухай хууль (An Act to amend the Financial Administration Act)-д нэмэлт өөрчлөлт оруулсан байна.¹²

30 (1) Олон нийтийн сайн сайхны тулд шаардлагатай хөрөнгийг яаралтай шийдвэрлэх нөхцөл

a. Парламент тарснаас хойш 60 хоногийн дотор сонгууль явагдаж дараагийн парламент бүрдэх тул парламент дөнгөж тарангуут.

b. Тухайн зүйлд зарцуулах хөрөнгө төсөвт тусгагдаагүй тохиолдолд

Олон нийтийн сайн сайхны тулд яаралтай хөрөнгө шаардагдсан нөхцөлд хөрөнгө шаардлагатай болсон салбарын сайдын гаргасан тайлбар, хүсэлтийн дагуу Төсвийн орлогын нэгдсэн сангаас шийдвэрлэх.

4. Сингапур

Эх сурвалж:

[https://www.parliament.gov.sg/docs/default-source/default-document-library/covid-19-\(temporary-measures\)-bill-19-2020.pdf](https://www.parliament.gov.sg/docs/default-source/default-document-library/covid-19-(temporary-measures)-bill-19-2020.pdf)

Тус улсын парламентаас 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр “Ковид-19 түр арга хэмжээний хууль 2020”-ыг (СТМА) баталсан. Тус хууль нь 6 сарын хугацаанд үйлчлэх бөгөөд дахин 6 сараар сунгаж 1 жилийн хугацаанд үйлчлэх боломжтой. Энэхүү хуулиар нэг талд нь Засгийн газар оролцож байгаа гэрээний үндсэн дээр ажил гүйцэтгэж буй аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжих зорилготой хууль юм.

Тус хуульд дараах асуудлуудыг зохицуулсан. Үүнд:

- Гэрээний үүргээ биелүүлэх төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд түр зуурын тусламж үзүүлэх;
- Санхүүгийн хувьд хүнд байдалд орсон хувь хүн, фирм болон бусад бизнесүүдэд түр зуурын тусламж үзүүлэх;
- Уулзалт, хурал зохион байгуулах түр зуурын арга хэмжээний талаар;
- Шүүх болон шариатын шүүх хуралдааны үйл ажиллагааны түр зуурын арга хэмжээ;
- Ковид-19 хяналт тавих журам.

¹² https://laws-lois.justice.gc.ca/eng/AnnualStatutes/2020_4/page-1.html

Үндсэн сэдэв	Гол заалт	Гол утга
<p>Гэрээний үүргээ биелүүлэх төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд түр зуурын тусламж үзүүлэх</p>	<p>5-9</p>	<p>Ковид-19-ийн улмаас гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон буюу төлбөрийн чадваргүй болсон талд “А” талаас хийх зарим арга хэмжээнүүдийг хориглосон. Энэхүү хууль нь 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс хойш, 3 дугаар сарын 25-наас өмнө хийгдсэн болон шинэчлэгдсэн гэрээнд хамаарна. Гэрээний нэг тал болох Б тал нь энэхүү хуульд багтаагүй тохиолдолд түр зуурын дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдахгүй.</p> <p>Ковид-19 үйл ажиллагаа гэж:</p> <ul style="list-style-type: none"> - Ковид-19-ийн голомтот халдвар эсвэл тархалт - Ковид-19-тэй холбоотой эсвэл энэ шалтгаанаар гаргасан бүх төрлийн хууль, дүрэм журам, зөвлөгөөг Сингапур эсвэл өөр улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд, төрийн эрх бүхий байгууллага хэрэгжүүлэх, дагаж мөрдөх үйл ажиллагааг хамааруулна. <p>Энэхүү хуулийн 5 дугаар зүйлд дараах арга хэмжээнүүдийг хориглосон. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> a. А тал эсвэл А талын батлан даагчийн эсрэг шүүхийн үйл ажиллагаа явуулах; b. Арбитрын тухай хуулийн дагуу А тал, түүний батлан даагчийн эсрэг Арбитрын үйл ажиллагаа явуулах; c. Үл хөдлөх хөрөнгийг албадан гүйцэтгүүлэх; d. Худалдаа, бизнес эсвэл мэргэжлийн зорилгоор ашигласан хөдлөх эд хөрөнгийг албадан гүйцэтгүүлэх; e. Компанийн тухай хуулийн 210 зүйлийн дагуу зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлэхэд зориулсан өргөдөл гаргах; f. А тал, түүний батлан даагчийг дампууруулах, компанийг татан буулгах өргөдөл гаргах; g. Төлбөрийн чадваргүй болсон этгээд түрээсийн болон бусад төлбөрийг төлөөгүй тохиолдолд гэрээг цуцлах (үл хөдлөх эд хөрөнгийн лиценз болон түрээсийн төлбөр хамаарна); h. Барилга болон барилга үйлдвэрлэлийн төлбөрийн аюулгүй байдлын тухай хуулийн тодорхойлолт болон Арбитрын тухай хуулийн дагуу шүүх, Арбитрын шийдвэрийг биелүүлэхийг тус тус хориглосон. <p>Арбитрын хуулийн дагуу эхлээгүй Арбитрын үйл ажиллагааг хориглохгүй. Төлбөрийн чадваргүй байдал нь Ковид-19-ийн улмаас үүссэн бол гэрээний шаардлагыг биелүүлээгүйгээс үүсэх асуудлаас хамгаална. Хуулийн 7 дугаар зүйлд зааснаар төлбөрийн чадваргүй этгээдийн зарим арга хэмжээнд хамаарах болон аялал жуулчлалтай холбоотой гэрээний дагуу барьцаа (хадгаламж) хөрөнгийг хурааж болохгүй. Хэрэв хураасан бол сэргээнэ.</p>

ТӨЛӨӨЛӨГЧ (ASSESSORS)

Энэ хуулийн 13 дугаар зүйлд Төлөөлөгч хуулийн 5, эсхүл 7 дугаар зүйлд заасны дагуу **өргөдөл хүсэлтээ** (application) тодорхойлохоор зохицуулсан.

Төлөөлөгч нь хуулийн 13 (2) дугаар зүйлд заасны дагуу А талын санхүүгийн чадавх болон боломжийг харгалзан үзэж болно.

Төлөөлөгч нь хуулийн 13(3) дугаарт заасны дагуу талын тухайн нөхцөлд олсон үр ашгийн талаар үнэн зөв тодорхойлолтыг авч болно (талын хийсэн аливаа үйлдэл, эсхүл өр зээлээ төлсөн мөнгөний талаарх мэдээллийг багтаасан).

Энэ тохиолдолд төлөөлөгчийн тодорхойлолтыг давж заалдахгүй гэж хуулийн 13(10) дугаарт заасан байна.

Хуульчид шүүх хурлын үеэр төлөөлөгчийн өмнө талуудад зааварчилгаа өгөхгүй (хуулийн 14 дүгээр зүйл). Гэхдээ талуудад **өргөдөл хүсэлтээ** бэлтгэх болон хэргийн талаар зөвлөгөө өгнө.

Талууд төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлыг өөрсдөө хариуцна (хуулийн 15 дугаар зүйл)

ТӨЛӨВЛӨГДСӨН ГЭРЭЭ (SCHEDULED CONTRACTS)

Хуульд зааснаар **Төлөвлөгдсөн гэрээнд** дараах тохиолдлууд орно.

- Сингапур дахь арилжааны болон үйлдвэрлэлийн аливаа үл хөдлөх хөрөнгийг бүтнээр, эсхүл хэсэгчлэн хамгаалах банкны эсхүл, санхүүгийн компаний зээлийн хөнгөлөлт
- байгууллагад зориулсан банкны эсхүл, санхүүгийн компаний зээлийн хөнгөлөлт. Үүнд:
 - Сингапур дахь үйлдвэрийн тоног төхөөрөмж, ташин механизм, үндсэн хөрөнгийг бүтнээр, эсхүл хэсэгчлэн хамгаалах хөнгөлөлт
 - Боловсруулах үйлдвэрлэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон бусад бизнесийн зориулалтаар хэрэглэгдэх үйлдвэрийн тоног төхөөрөмж, машин механизм, үндсэн хөрөнгө орно.
- барилгын гэрээ, эсхүл нийлүүлэлтийн гэрээний дагуу олгосон гүйцэтгэлийн бонд буюу түүнтэй адилтгах хөрөнгө;
- Түрээслэх-худалдан авах тухай хуульд заасны дагуу түрээслэх-худалдан авах гэрээ, эсхүл нөхцөлт борлуулалтын гэрээ. Үүнд:
 - Сингапур дахь арилжааны, үйлдвэрлэлийн болон бусад зориулалтаар хэрэглэгдэх үйлдвэрийн тоног төхөөрөмж, машин механизм, үндсэн хөрөнгө
 - Арилжааны тээврийн хэрэгсэл (commercial vehicle)

-
- Үйл ажиллагааны гэрээ (тодорхой хугацаатай)
 - Аялал жуулчлалын гэрээ (тодорхой хугацаатай)
 - Барилга байгууламжийн гэрээ, эсхүл нийлүүлэлтийн гэрээ
 - Түрээс, эсхүл орон сууцны бус үл хөдлөх хөрөнгийн лиценз.

“Байгууллага” (Enterprise) – Сингапурт бүртгэлтэй бөгөөд үйл ажиллагаа эрхэлдэг хувь нийлүүлсэн болон хувь нийлүүлээгүй аливаа этгээдийг хэлнэ. (хувьцаа, эсхүл эзэмших эрхийн хамгийн багадаа 30 хувь нь Сингапурын иргэн, эсхүл байнга оршин суух эрх бүхий иргэн эзэмшдэг байх, мөн эргэлтийн хөрөнгө нь хамгийн сүүлийн санхүүгийн жилд 100 сая доллароос хэтрээгүй байх)

Сингапурын худалдааны хөрөнгө, эсхүл худалдааны түрээслэх-худалдан авах хөрөнгө зээлтэй бизнесийн байгууллагад чиглэнэ. **Баталгаат бус** зээл (Unsecured loans) хувь хүмүүст зориулсан зээлд хамааралгүй болно.

“Үйл ажиллагааны гэрээ” (Event contract) – танхим, заал (venue) байр сууц, тохь тухтай орчин, тээвэр, зугаа цэнгэл, катеринг, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой дараах зүйлийг хамрах гэрээ юм.

- Бизнесийн уулзалт, урамшуулалт аялал, хурал, үзэсгэлэн, борлуулалтын үйл ажиллагаа, концерт, тоглолт, хурим, үдэшлэг, бусад олон нийтийн арга хэмжээ, биеийн тамирын арга хэмжээ.
- Дээрх үйл ажиллагаанд оролцогчид, зочид, дэмжигч, үзэгч.

Аялал жуулчлалын гэрээ (Tourism-related contract) гэж дараах зүйлтэй холбоотой гэрээг хэлнэ.

- Далайн болон газрын олон улсын зорчигч тээвэр
- Дотоодын болон гадаадын жуулчдыг тээвэр, богино хугацааны орон байр, зугаа цэнгэл, хоолны газар, катеринг, аялал жуулчлалын зориулалттай бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах
- Сингапур улсын аялал жуулчлалыг урамшуулах, эсхүл аялал жуулчлалын холбогдолтой бараа бүтээгдэхүүний худалдаа болон жижиглэнгийн худалдааг түгээх.

Уулзалт, хурал зохион байгуулах түр зуурын арга хэмжээний талаар	27	Хуулийн 27(1) дүгээр зүйлд Сайд хурал, уулзалтыг хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр зохион байгуулж болно гэж заасан. Үүнд дараах хэлбэрүүд байж болно. <ul style="list-style-type: none"> – хурал, уулзалтыг цахим харилцаа холбоо ашиглах, видео хурал хийх гэх мэт хэлбэрээр явуулах; – ирцийг хязгаарлах; – санал хураалтыг цахим хэлбэрээр, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан явуулах; – асуулт, хариултыг цахимаар, эсхүл бичгэн хэлбэрээр явуулах.
Шүүх болон шариатын шүүх хуралдааны үйл ажиллагааны түр зуурын арга хэмжээ	28	Шүүх хуралдааныг гэрч, яллагдагчийн оролцоотойгоор алсын зайнаас явуулж болно. Ингэхдээ үүнд бүх шүүх хуралдаан хамаарахгүй байна. Одоогийн байдлаар Дээд шүүх дээр 2020 оны 4-р сарын 7-ны өдрөөс 2020 оны 5-р сарын 4-ний хооронд хэлэлцэхээр товлогдсон нэн яаралтай, чухал асуудлаас бусад асуудлыг хойшлуулна.
Хөрөнгийн албан татвараас чөлөөлөх түр арга хэмжээ	29-33	Хуулийн 29(2) дугаарт заасны дагуу Ковид 19-ийн тархалттай холбоотой хөрөнгө эзэмшигч нь татварын чөлөөлөлт эдлэх бөгөөд ингэснээр түрээслэгчдийг хөнгөлөлт юм. Эзэмшигч нь 3 жил хүртэлх хугацааны гэрчилгээтэй байх ёстой (хуулийн 29(5) дугаар зүйл). Эзэмшигчийн хүртэх үр ашиг болон түүний хэмжээ, хэлбэр, цаг хугацаа, эсхүл хуулийн 29(2) дугаар зүйлийг дагаж мөрдөөгүйтэй холбоотой аливаа маргааныг хуулийн 30(5) дугаар зүйлд заасны дагуу Үнэлгээний хяналтын панель шийдвэрлэнэ. Тухайн асуудалтай холбоотой өргөдөл нь хөөн хэлэлцэх хугацаатай (хуулийн 30(5) дугаар зүйл)

5.ОХУ

Эх сурвалж:

<http://duma.gov.ru/news/48209/>

		ОХУ	
Өнөөгийн нөхцөл байдал	2020.04.09-ний өдөр Москвагийн цагаар 10.45 цагийн байдлаар	Батлагдсан нийт тохиолдол:	10 131 (+1 459)
		Эдгэрсэн:	698 (+ 118)
		Нас барсан:	76 (+ 13)
Батлагдсан хууль	2020.03.31-ний өдөр ОХУ-ын Төрийн Дум “КОВИД-19”-ын халдварын тархалттай холбоотойгоор дор дурдсан 10 гаруй багц хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж баталсан байна:		

**тогтоомжийн
нэр, огноо**

- **Урьдчилан сэргийлэх, онц байдлын үед хариу арга хэмжээ авахтай холбоотой хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар**¹³
 - 1) ОХУ-ын Засгийн газарт шинэ бүрэн эрх олгов;
 - 2) эм дамлан худалдахыг хориглов;
 - 3) шинэ эмийн бүртгэлийг хялбаршуулав;
 - 4) бизнесийн аудитыг түр хугацаагаар түдгэлзүүлэв;
 - 5) зөвшөөрөл сунгах хугацааг хойшлуулав;
 - 6) орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний өрийг торгох асуудлыг хойшлуулав;
 - 7) жуулчдыг хамгаална;
 - 8) техникийн үзлэгийг хойшлуулав;
 - 9) цуцлагдсан урлагийн тоглолтын тасалбарыг буцааж олгоно;
- **ОХУ-ын төсвийн тухай хуулийн зарим заалтыг түдгэлзүүлэх, 2020 онд холбооны төсвийг хэрэгжүүлэх онцлог шинжийг тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар**¹⁴
 - 10) төсвийн тодотгол яаралтай хийх;
 - 11) бүс нутгуудад дэмжлэг үзүүлнэ;
- **Мэдээлэл, мэдээллийн технологи болон мэдээллийг хамгаалах тухай хуулийн 15.1 болон Эмийн хангамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар**¹⁵
 - 12) эмийг цахимаар худалдана;
- **ОХУ-ын Төв банкны тухай болон зээлийн гэрээний нөхцөлтэй холбоотой бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль тогтоомжоор**¹⁶
 - 13) иргэд, ЖДҮ эрхлэгчдийн зээл төлөх хугацааг 6 сараар хойшлуулах боломжтой;
- **Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, эхний, эсхүл хоёр дахь хүүхэд нь төрсөнтэй холбогдуулан сарын бүрийн төлбөр олгох тухай хуулиар**¹⁷
 - 14) эмнэлгийн хуудасны төлбөрийг нэмэв;
 - 15) хүүхэдтэй гэр бүлд дэмжлэг үзүүлнэ;

¹³ О внесении изменений в отдельные законодательные акты Российской Федерации по вопросам предупреждения и ликвидации чрезвычайных ситуаций (в части урегулирования отношений, возникающих в связи с необходимостью экстренного реагирования на вызовы, связанные с распространением новой коронавирусной инфекции, вызванной 2019-nCoV)

¹⁴ О внесении изменений в Федеральный закон "О приостановлении действия отдельных положений Бюджетного кодекса Российской Федерации и установлении особенностей исполнения федерального бюджета в 2020 году"

¹⁵ О внесении изменений в статью 15.1 ФЗ «Об информации, информационных технологиях и о защите информации» и Федеральный закон «Об обращении лекарственных средств»

¹⁶ О внесении изменений в ФЗ «О Центральном банке Российской Федерации (Банке России)» и отдельные законодательные акты Российской Федерации в части особенностей изменения условий кредитного договора, договора займа

¹⁷ Об особенностях исчисления пособий по временной нетрудоспособности и осуществления ежемесячных выплат в связи с рождением (усыновлением) первого или второго ребенка

- **Захиргааны зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар**¹⁸
 - 16) эмийн үнийг өсгөвөл торгууль ногдуулна;
 - 17) эрүүл ахуй, тахал судлалын хууль тогтоомж зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгав;
 - 18) онц байдлын үед тогтоосон журам зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагыг нэмж оруулав;
 - 19) “КОВИД-19”-ын худал мэдээлэл тараасан этгээдэд торгууль ногдуулна;
- **Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар**¹⁹
 - 20) чанар муутай (хуурамч) эм худалдсан этгээдэд хариуцлага тооцно;
 - 21) хорио цээрийн дэглэм зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгав.
- **Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар**²⁰
 - 22) хандив цуглуулах журамд өөрчлөлт оруулав;

Жич: Дээрх хуулиуд 2020.04.10-ний байдлаар албан ёсоор нийтлээгүй байна.

Эх сурвалж: ОХУ-ын Төрийн Думын цахим хуудас (<http://duma.gov.ru/news/48209/> - 2020.04.03, <http://duma.gov.ru/news/48210/> - 2020.04.01, <http://duma.gov.ru/news/48196/> , <http://duma.gov.ru/news/48191/> , - 2020.03.31)

Засгийн газарт онцгой бүрэн эрх олгосон эсэх (Ковидтой холбоотой асуудлаар парламентаас Засгийн газар бүрэн эрхээ олгосон эсэх)

- 1) Урьдчилан сэргийлэх, онц байдлын үед хариу арга хэмжээ авахтай холбоотой хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу **ОХУ-ын Засгийн газарт шинэ бүрэн эрх олгов:**
 - нийгэмд аюул учруулж болзошгүй өвчин тархах тохиолдолд онц байдал, эсхүл онцгой бэлэн байдал зарлах;
 - урьдчилан сэргийлэх, онц байдлын үед хариу арга хэмжээ авах улсын нэгдсэн тогтолцоог зохицуулах байгууллагын эрх, үүргийг хэрэгжүүлэх;
 - онц байдал, эсхүл онцгой бэлэн байдал зарласан тохиолдолд иргэд, байгууллагуудын дагаж мөрдөх журмыг тогтоох;
 - “КОВИД-19”-ын халдварын тархалттай холбоотой тулгамдсан асуудлыг яаралтай шийдвэрлэж, хүмүүст болон тус улсад үзүүлэх сөрөг үр дагаврыг багасгахын тулд шаардлагатай бүх арга хэмжээг авах;
 - мөн бүс нутгийн эрх баригчид хамгаалалтын зохих арга хэмжээг хэрэгжүүлэх.
- 2) ОХУ-ын төсвийн тухай хуулийн зарим заалтыг түдгэлзүүлэх, 2020 онд холбооны төсвийг хэрэгжүүлэх онцлог шинжийг тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу **төсвийн тодотгол яаралтай хийх:**

¹⁸ О внесении изменений в Кодекс Российской Федерации об административных правонарушениях

¹⁹ О внесении изменений в Уголовный кодекс Российской Федерации и статьи 31 и 151 Уголовно-процессуального кодекса Российской Федерации

²⁰ О внесении изменения в Федеральный закон «О благотворительной деятельности и добровольчестве (волонтерстве)» (в части введения понятия и видов ящиков для сбора пожертвований)

-холбооны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр “КОВИД-19”-ын халдвараас урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгахтай холбоотой арга хэмжээг цаг алдалгүй санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд Засгийн газар шаардлагатай хөрөнгийг хуваарилах эрхтэй;
-одоогийн санхүүгийн жил, төлөвлөгөөт хугацаанд төсвийг дахин хуваарилахад нь хяналт тавих үүднээс ОХУ-ын Холбооны Хурал Комисс байгуулан төсвийн хуваарилалтад парламентын хяналтыг хангах санал гаргав.

**Эрүүл мэндийн
цогц арга
хэмжээ**

- 3) Мэдээлэл, мэдээллийн технологи болон мэдээллийг хамгаалах тухай хуулийн 15.1 болон Эмийн хангамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу **эмийг цахимаар худалдана:**
-жоргүй олгодог эмийн захиалгаа цахимаар өгч, гэртээ хүргүүлэх боломжтой болсон;
-жороор олгох эмийг тахал тархсан, эсхүл онц байдлын үед цахимаар зарж болно;
-жороор олгох эмд мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой эм хамаарахгүй.
- 4) Урьдчилан сэргийлэх, онц байдлын үед хариу арга хэмжээ авахтай холбоотой хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр **эм дамлан худалдахыг хориглов:**
-Засгийн газар онц байдлын үед, эсхүл нийгэмд аюул учруулж болзошгүй өвний үед (тодорхой жагсаалтад орсон) эмнэлгийн бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдааг 90 хоногийн турш хязгаарлаж болно. Энэ нь тухайлбал, эмнэлгийн маскыг дамлан худалдаж авахаас зайлсхийх ба шаардлагатай стратегийн эмийн хангамжийг бий болгоно.
- 5) Урьдчилан сэргийлэх, онц байдлын үед хариу арга хэмжээ авахтай холбоотой хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулснаар **шинэ эмийн бүртгэлийг хялбаршуулав:**
-ОХУ-д шинэ эмийг бүртгэх хялбаршуулсан журмыг нэвтрүүлж байна;
-Энэ нь тахалын үед шинэ эмийг зах зээлд шуурхай нэвтрүүлэх боломжийг олгоно;
-Шаардлагатай бол эмийг нэг ханган нийлүүлэгчээс худалдаж авч болно;

**Эдийн засгийн
хариу арга
хэмжээ**

- 6) ОХУ-ын төсвийн тухай хуулийн зарим заалтыг түдгэлзүүлэх, 2020 онд холбооны төсвийг хэрэгжүүлэх онцлог шинжийг тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу **бүс нутгуудад дэмжлэг үзүүлнэ:**
-Засаг дарга нарт “КОВИД-19”-ын халдварын тархалтын үр дагаврыг арилгахтай холбоотой үйл ажиллагаанд нь нэмэлт санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжтой иж бүрэн арга хэрэгслээр хангаж байна;
-бүсүүд 2020 оны төсвийн зээлийн төлөлтөөс чөлөөлөв (энэ нь бүс нутгууд 78 тэрбум рублийг хэмнэх боломжтой);
-чөлөөлөгдсөн хөрөнгө нь “КОВИД-19”-ын халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгахтай холбоотой арга хэмжээ, нийгэм, эдийн засгийн нэмэлт арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр болно;
-бүс нутгийн төсвийн үлдэгдлийг 90-180 хоногийн дотор нөхөх зорилгоор төрийн сангийн зээл олгох хугацааг сунгаж, өр төлбөрийг татах хязгаарлалтыг хөнгөлөв.
-

-
- 7) ОХУ-ын Төв банкны тухай болон зээлийн гэрээний нөхцөлтэй холбоотой бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль тогтоомжоор [иргэд, ЖДҮ эрхлэгчдийн зээл төлөх хугацааг 6 сараар хойшлуулах хүсэлтэй өргөдөл гаргаж болно:](#)
-үүнд хэрэглээний болон ипотекийн зээлд хамаарна;
-өнгөрөгч сарын орлого 30 ба түүнээс бага хувьтай байсан зээлдэгчид хамаарна;
-зээл төлөх хугацааг хойшлуулах боломжтой бизнесийн салбарын жагсаалтыг ОХУ-ын Засгийн газар батална.
- 8) Урьдчилан сэргийлэх, онц байдлын үед хариу арга хэмжээ авахтай холбоотой хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулснаар [бизнесийн аудитыг түр хугацаагаар түдгэлзүүлэв:](#)
-2020 оны дустал ЖДҮ-үүдэд хийгдэх хяналт шалгалтыг түдгэлзүүлэв;
-мөн дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “мораторий” нэвтрүүлэх боломжтой, учир нь тахал өвчин нь тухайн ААН-ийн санхүүгийн байдалд нөлөөлж болзошгүй тул ААН-үүд өөрсдийгөө болон ажлын байраа хадгалах боломжтой.
- 9) Урьдчилан сэргийлэх, онц байдлын үед хариу арга хэмжээ авахтай холбоотой хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулснаар [зөвшөөрөл сунгах хугацааг хойшлуулав:](#)
-зөвшөөрөл (лиценз, итгэмжлэл гм)-ийн хүчинтэй хугацаа дуусаж байгаа бол энэ хугацаанд тэдгээрийн сунгуулах хүсэлтийг гаргах шаардлагагүй, ашиглалтын хугацаа автоматаар сунгагдана;
-тухайлбал, худалдааны төвүүд хаагдсантай холбоотойгоор үйл ажиллагаагаа түр зогсоосон байгууллагууд түрээсийн төлбөрөө хойшлуулж болно.

**Нийгмийн
халамж,
хамгааллыг
дэмжих арга
хэмжээ**

- 10) Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, эхний, эсхүл хоёр дахь хүүхэд нь төрсөнтэй холбогдуулан сарын бүрийн төлбөр олгох тухай хуулиар [эмнэлгийн хуудасны төлбөрийг нэмэв:](#)
-өвчтөний эмнэлгийн хуудасны төлбөр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна;
-ОХУ-ын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2020.01.01-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12,130 рубль байхаар санал гаргав.
- 11) Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, эхний, эсхүл хоёр дахь хүүхэд нь төрсөнтэй холбогдуулан сарын бүрийн төлбөр олгох тухай хуулиар [хүүхэдтэй гэр бүлд үзүүлэх дэмжлэг:](#)
-эхний, эсхүл хоёр дахь хүүхдийн төлбөрийг хүлээн авч байгаа эцэг эхчүүд 2020.10.01-ний өдрийг дуустал төлбөр авах (хугацаа сунгах) өргөдлийг гаргах шаардлагагүй;
-төлбөрийг автоматаар хийнэ.
-

- 12) Урьдчилан сэргийлэх, онц байдлын үед хариу арга хэмжээ авахтай холбоотой хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулснаар [орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний өрийг торгох асуудлыг хойшлуулав](#): -2020 онд орон сууцны үйлчилгээний төлбөр төлөөгүй хэтрүүлсэн иргэдэд торгууль, алданги тооцохгүй.

Хариуцлагыг чангатгах чиглэлээр авч буй арга хэмжээ

- 13) Захиргааны зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар [эмийн үнийг өсгөвөл торгууль ногдуулна](#):

	Хүлээлгэх хариуцлага
эрх бүхий албан тушаалтанд	250-500 мян. рубль
хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчдэд	эмийг хууль бус өндөр үнээр борлуулснаас олсон орлогоос 2 дахин их хэмжээний мөнгөн торгууль (гэхдээ 1 жилийн орлогоос хэтрэхгүй байх)

- 14) Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар [чанар муутай \(хуурамч\) эм худалдсан этгээдэд хариуцлага тооцно](#):

- 4-5 хүртэлх жилээр албадан ажил хийх;
- 2-3 хүртэлх жилээр тодорхой албан тушаал эрхлэхийг хориглох;
- иргэнд - 75-200 мян. рубль, эрх бүхий албан тушаалтан, хувиараа бизнес эрхлэгчид - 150-600 мян. рубль, хуулийн этгээдэд - 2-6 сая рублээр тус тус торгох;
- байгууллагын хувьд үйл ажиллагааг нь 90 хүртэл хоногоор зогсоох.

- 15) Захиргааны зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд²¹ [эрүүл ахуй, тахал судлалын хууль тогтоомж зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгав](#):

	Торгууль	Үйл ажиллагааг зогсоох / мэргэжлээр нь ажиллуулахгүй байх
Зөрчил гаргасан бол		
– иргэнд	15-40 мян. рубль	
– эрх бүхий албан тушаалтан, хувиараа бизнес эрхлэгчдэд	50-150 мян. рубль	
– хуулийн этгээд	200-500 мян. рубль	<90 хоног

²¹ О внесении изменений в Кодекс Российской Федерации об административных правонарушениях, В статье 6.3 «Нарушение законодательства в области обеспечения санитарно-эпидемиологического благополучия населения»

Хэрэв бусдын эрүүл мэнд, эсхүл амь насыг хохироосон боловч энэ нь эрүүгийн гэмт хэргийг агуулаагүй бол		
– иргэнд	150-300 мян. рубль	
– эрх бүхий албан тушаалтанд	300-500 мян. рубль	<3 жил
– хувиараа бизнес эрхлэгчид, хуулийн этгээд	500 мянгаас 1 сая рубль	<90 хоног

16) Захиргааны зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд²² онц байдлын үед тогтоосон журам зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагыг нэмж оруулав:

	Торгууль	Үйл ажиллагааг зогсоох / мэргэжлээр нь ажиллуулахгүй байх
Зөрчил гаргасан (эс үйлдэл) бол		
– иргэнд	1-3 мян. рубль	
– эрх бүхий албан тушаалтанд	10-50 мян. рубль	
– хувиараа бизнес эрхлэгчдэд	30-50 мян. рубль	
– хуулийн этгээдэд	100-300 мян. рубль	
Хэрэв зөрчил давтан гаргасан, эсхүл бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан бол		
– иргэнд	15-50 мян. рубль	
– эрх бүхий албан тушаалтанд	300-500 мян. рубль	<3 жил
– хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчдэд	500 мянгаас 1 сая рубль	<90 хоног

17) Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 31, 151 дүгээр зүйлд өөрчлөлт оруулах тухай хуулиар хорио цээрийн дэглэм зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгав:

	Торгууль	Хорих шийтгэл
зөрчил гаргасан бол	500-700 мян. рубль	<2 жил
хэрэв болгоомжгүйгээс болж хүний амь нас хохирсон бол	1-2 сая рубль	3-5 жил

²² О внесении изменений в Кодекс Российской Федерации об административных правонарушениях, вводится новая статья 20.6.1 «Невыполнение правил поведения при чрезвычайной ситуации или угрозе ее возникновения»

хэрэв ариун цэврийн-эпидемиологийн дүрмийг зөрчсөнөөс болж
2 ба түүнээс дээш хүний амь нас хохирсон бол

5-7 жил

18) Захиргааны зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд ²³ “КОВИД-19”-ын худал мэдээлэл тараасан этгээдэд торгууль ногдуулна:

хуулийн этгээдэд

-иргэдийн амь нас, аюулгүй байдалд заналхийлж буй нөхцөл байдлын тухай, хүн ам, нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, эдгээр нөхцөл байдлаас хамгаалах арга, арга хэрэгслийн талаар хуурамч мэдээлэл тараасан тохиолдолд хуулийн этгээдэд 1.5-3 сая рублийн торгууль ногдуулна;

-хэрэв энэ үйлдэл нь бусдын амь нас хохирсон, эсхүл бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан, эсхүл нийтийн хэв журмыг их хэмжээгээр зөрчихөд хүргэсэн бол торгуулийн хэмжээ 3-5 сая рубль болно;

-давтан зөрчил гаргасан бол торгуулийн хэмжээ 10 сая хүртэл рубль болно;

иргэдэд

-нийгмийн ач холбогдолтой хуурамч мэдээллийг олон нийтэд түгээсэн болгоомжгүй үйлдлийн улмаас бусдын эрүүл мэндэд хохирол учруулсан бол Эрүүгийн хуулийн 207.2-т заасан шинэ эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ – 700 мянгаас 1.5 сая хүртэл рублэр торгох, эсхүл 3 хүртэл жил албадан ажил хийлгэх, эсхүл 3 хүртэл жилийн хорих ялаар шийтгүүлнэ;

-хэрэв ийм болгоомжгүй үйлдлийн улмаас бусдын амь нас хохирсон, эсхүл бусдад үнд үр дагаварт хүргэсэн бол 1.5-2 сая рублийн торгууль, эсхүл 5 хүртэл жил албадан ажил хийлгэх, эсхүл 4 хүртэл жилийн хорих ялаар шийтгүүлнэ.

**Бусад
(Тухайлбал,
Сонгууль
зохион
байгуулах)**

19) Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу **хандив цуглуулах журамд өөрчлөлт оруулав:**

-зөвхөн хуулиар тогтоосон олон нийтийн арга хэмжээ зохион байгуулагдах үед суурин хайрцгийг байрлуулж ашиглах, зөврийн хайрцгийг ашиглах нөхцөлийг тодорхойлсон;

-хандивын хайрцгийг ашиглаж байгаа ашгийн бус байгууллага нь хандив цуглуулах үйл ажиллагааны хөтөлбөр, эсхүл бусад зохицуулалттай байх ба цугларсан хандивын ашиглалтын тайланг (тухайлбал, байгууллагын цахим хуудсанд) нийтлэнэ.

²³ О внесении изменений в Кодекс Российской Федерации об административных правонарушениях, вводится новая статья 20.6.1 «Невыполнение правил поведения при чрезвычайной ситуации или угрозе ее возникновения»

-
- 20)** Урьдчилан сэргийлэх, онц байдлын үед хариу арга хэмжээ авахтай холбоотой хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулснаар **жуулчдыг хамгаална:**
- аялал жуулчлалын операторуудын хувь хүний хариуцлагын санд төлбөр төлөх хугацааг өөрчлөх боломжтой;
 - ийм эх үүсвэрийг хилээ хаасан орнуудын (Засгийн газрын шийдвэрээр) жуулчдад төлбөрийг нь буцаахад зориулсан санд ашиглах механизмыг санал болгов;
 - аялал нь амралтын хугацаанд цуцлагдсан жуулчдын төлбөрийг бүрэн буцаан олгоно;
 - харин аялалаа хэсэгчлэн хийгээгүй жуулчдын төлбөрийг нь түүнд үзүүлээгүй үйлчилгээний үнийн дүнгээс хувь тэнцүүлэн тооцож буцаан олгоно.
- 21)** Урьдчилан сэргийлэх, онц байдлын үед хариу арга хэмжээ авахтай холбоотой хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулснаар **техникийн үзлэгийг хойшлуулав.**
- засвар үйлчилгээний шинэ дүрмүүдийн хүчин төгөлдөр болох хугацааг 2021 он болгож хойшлуулсан;
 - ашиглалтын хугацаа 4 жилээс бага автомашинуудыг техникийн үзлэгээс бүрэн чөлөөлөв;
 - ашиглалтын хугацаа 4-10 жил байгаа автомашинуудын техникийн үзлэгийг 2 жил тутамд хийнэ;
 - ашиглалтын хугацаа 10 жилээс дээш байгаа автомашинуудын техникийн үзлэгийг жил бүр хийнэ;
- 22)** Урьдчилан сэргийлэх, онц байдлын үед хариу арга хэмжээ авахтай холбоотой хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулснаар **цуцлагдсан урлагийн тоглолтын тасалбарыг буцааж олгоно:**
- онц байдал, эсхүл онцгой бэлэн байдал зарласан үед соёлын арга хэмжээг цуцлах, эсхүл хойшлуулах боломжтой бөгөөд ийм нөхцөлд тасалбарын үнийг иргэдэд буцааж өгнө.
-

6.ХБНГУ

Эх сурвалж:

1. Холбооны Улсын Эрүүл мэндийн Яам <https://www.bundesgesundheitsministerium.de/coronavirus.html>
2. 2020 coronavirus pandemic in Germany https://en.wikipedia.org/wiki/2020_coronavirus_pandemic_in_Germany
3. COVID-19-Fälle in Deutschland https://de.wikipedia.org/wiki/COVID-19-F%C3%A4lle_in_Deutschland
4. Үндэсний пандемийн төлөвлөгөө-Шинэ төрлийн корона вирусний өвчлөлийн нэмэлт *"Ergänzung zum Nationalen Pandemieplan – COVID-19 – neuartige Coronaviruserkrankung"* (PDF). *www.rki.de. Robert Koch Institute. Retrieved 4 March 2020.*
5. “Америкчууд вирусийн тархалтын улмаас галт зэвсэг ихээр худалдаж авч буй тул АНУ-д буй Монголчууд сонор сэрэмжтэй байх нь зүйтэй” Монгол Улсын Тагнуулын Ерөнхий газар <http://www.sonin.mn/news/culture/109580>
6. Гадаад Харилцааны Яамны Танилцуулах мэдээ №01/16 2020-03-27

7. Bundestag: Umfangreiche Maßnahmenpakete zum Bewältigen der Corona-Krise <https://www.cducsu.de/themen/bundestag-umfangreiche-massnahmenpakete-zum-bewaeltigen-der-corona-krise>
8. POLICY RESPONSES TO COVID-19 https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19?fbclid=IwAR0s3AHnfC2wAk_-dMLMFdAMRIXtFGaVQz7Z0Rh6IkXv8eWPTBvr-xCdjxE#G

ХБНГУ

Нөхцөл байдал	<p>2020-03-11 Канцлер А.Меркель мэдэгдэл хийв:⁴ -Компаниудын төлбөрийн чадварыг дэмжих зорилгоор Германы хөгжлийн банк (KfW)–наас энэ 7 хоногтоо багтаан санхүүжилт олгоно.</p>
Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээнүүд	<p>2020-01-31 Халдвараас хамгаалах хуулийн 6 ба 7 дахь зүйлийг үндэслэн “бүртгүүлэх үүрэг”-ийг журамлав. Тус журмаар, мөн сэжигтэй тохиолдол батлагдаагүй ч бүртгүүлэх үүрэг хүлээнэ.³</p> <p>2020-02-27 Дотоод хэргийн болон Эрүүл мэндийн яамны хамтарсан хямралын штаб байгуулагдав.³</p> <p>2020-03-02 Олон нийтийн эрүүл мэндийн Эрсдэлийн үнэлгээний түвшинг ахиулж “тааруу” гэж зарласан.³</p> <p>2020-03-04 Үндэсний пандемийн төлөвлөгөөнд корона вирусын өвчлөлийн талаар нэмэлт оруулав.⁴</p> <p>2020-03-06-ны өдрөөс хойш Норд-райн-вэст-фалэн муж улсын Хайнсберг тойргийг “онцгой тархалттай бүс”-ээр зарласан.³</p> <p>2020-03-11 ДЭМБ “цар дэгдэлт” (пандеми) зарлав.³</p> <p>2020-03-11 Бундестаг коронавирусын талаар Засгийн газрын сонсгол хийв.¹</p> <p>2020-03-12 Хэдийгээр хил залгаа улс орнууд дунд сургуулийг хаасан байгаа ч Германы Боловсролын сайд сургуулийг хаах тухай асуудал огт яригдахгүй гэж мэдэгдлээ.</p> <p>2020-03-13 Германы 16 улсын 14 нь дунд сургууль, цэцэрлэгийг хэдэн долоо хоногийн турш хаахаар шийдвэрлэв.</p> <p>2020-03-14 -Нэлээд хэдэн улсад олон нийтийн үйл ажиллагаа явуулахыг хориглов. Тухайлбал, Берлин, Шлесвиг-Холштайн, Заарланд улсуудад түүнээс гадна мөн баар, цэнгээнт газруудыг хаав. -Көлнд хотын төвд цуглахыг хориглов.</p> <p>2020-03-15 -Баварид хямралын дундуур орон нутгийн сонгууль явагдлаа. Сонгуулийн штабын олон ажилтан ажлын байраа орхисноос сонгууль үр дүнгүй болох эрсдэл нүүрлэв. -Германы Дотоод хэргийн сайдын шийдвэрээр Франц, Швейцар, Австри, Дани болон Люксембургтэй хилээ хаав. Арга хэмжээ Даваа гаригаас эхэлж хэрэгжих ба бараа тээвэр болон орон нутгийн нислэг хамаарахгүй аж. -Германы төмөр зам бүс нутгийн тээврээ хязгаарлаж, тийз шалгалтыг зогсоов.</p> <p>2020-03-16 -Бавари Улсад 14 хоногийн онц байдал зарлаж, олон нийтийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж, эмнэлгийн тусламж, хангамжид зориулан нэмэлт хөрөнгө гаргахаар шийдвэрлэв.</p>

-Бүх спортын болон цэнгээнт газруудыг хаав. Хооллох зориулалтаар ресторонууд 15:00 хүртэл ажиллана, гэхдээ зөвхөн 30 хүртэлх үйлчлэгч авна. Их дэлгүүр, химийн бодис зардаг дэлгүүр, банк, хөнгөн зуушны газар болон үндсэн хэрэгцээ хангадаг бүх төрлийн аж ахуйн нэгжүүд уртасгасан цагаар, бүр Ням гарагт ч ажиллаж болно. Харин чухал биш (барааны) дэлгүүрүүдийг бүгдийг хаана.³

-ХБНГУ-ын Тээврийн яам Иран, Хятадаас ирэх бүх нислэгийг зогсоолоо.³

-Үдэш нь Меркель Холбооны Улсын хэмжээнд Баваритай ижил арга хэмжээ авч байгааг мэдэгдэв, хот хоорондын тээвэр, шашны хурал цуглаанд нэгдэх, талбайд тоглох болон аялал жуулчлалыг хориглов.³

2020-03-17

-Роберт Кох Институт (RKI) Олон нийтийн эрүүл мэндийн Эрсдлийн үнэлгээний түвшинг ахиулж “өндөр” гэж зарлав.³

-Үдэш нь Меркель, ЕХ-ны бусад удирдагчидтай зөвшилцөн ЕХ-ны бус иргэнийг 30 хоногийн хугацаанд ЕХ руу нэвтрүүлэхгүй байхаар шийдвэрлэснийг мэдэгдэв.

-Европын комисс хамтарч анагаах механизм олох ажлыг эхлүүлэв.

2020-03-18

-Гёттинген Их сургуулийн эрдэмтэд корона вирусийн хүний эсэд бэхжин үлдэх чадварыг нойр булчирхайн үрэвсэл, зарим төрлийн хорт хавдрын эмчилгээнд хэрэглэдэг Япон Улсад үйлдвэрлэсэн “Мезилат Камостата” гэх эмээр устгах боломжтойг тогтоосон байна.⁵

-Роберт Кох Институт, хэрэв нийгмийн харилцааг (хавьтлыг) эрс бууруулахгүй, шууд харилцааг 1.5 метрээс доошгүй зайнд барихгүй бол өвчлөгчдийн тоо 10 сая хүрнэ хэмээн анхааруулав.

-ЕХ-ны Итали, Швейцар, Дани, Люксембург болон Испани улсын иргэдийг агаарын болон усан замаар Герман руу нэвтрэхийг хориглов. Хоёр талын хэлэлцээрийн дагуу Хятад, Иранаас агаарын тээврээр зорчигч хүлээж авч байсныгаа хоёр өдрийн өмнөөс эхлэн бүр мөсөн хориглов. Эдгээр зорчигчдоос вирусын шалгалт авалгүй, биеийн халууныг нь хэмжилгүй нэвтрүүлж байсан аж.

-Засгийн газраас ЕХ-ны бус оронд аялж явсан хэдэн мянган иргэнээ тусгай үүргийн онгоцоор татан авах ажиллагаа зохион байгуулав.

-Олон нийтийн эрүүл мэндийн даатгалын компаниуд хямралтай холбогдох бүх зардлыг ямар нэгэн хязгаарлалтгүйгээр нөхөн олгохоо мэдэгдэв.

2020-03-19 Германы нэгэн амны хаалт үйлдвэрлэгч бүх үйлдвэрлэсэн хаалтыг борлуулж дууссанаа мэдэгдэв. Зарим эмнэлэг хамгаалах хувцас дутагдаж буйгаа зарлав.

2020-03-19

-Бавари Улс анхлан 4 хоногийн өмнө Австри Улсад хэрэгжүүлсний нэгэн адил хөл хорионы цаг тогтоов. Хөл хорио 24 цагт эхэлнэ, зөрчигчид 25 мянга хүртэл еврогийн торгууль оногдуулна. Гэхдээ ажилд явах болон их дэлгүүр, ундааны дэлгүүр, эмийн сан руу ганцаар буюу гэр бүлийн нэг гишүүний хамтаар явахыг зөвшөөрсөн хэвээр аж. Мөн дээрх нөхцөлтэйгээр задгай талбайд спортоор хичээллэх, хамтран амьдрагчийндаа, эсвэл өндөр настныд зочлох, өвчтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асрах, ерөнхийдөө бүх төрлийн тусламж

үзүүлэх болон амьтан арчилж болно. Драйв-Ин болон Тэйк-Эвайгаас бусад бүх ресторан (хоолны газар), үсчний газрыг хаав.

-Заарланд Улс мөн 24:00 цагаас эхлэн хөл хорио тогтоов. Гэхдээ зарим хөнгөлөлттэй. Улс хооронд, ялангуяа Францтай хил залгаа нутгаар униформ буюу халааттай зорчихоор журамлав.

2020-03-21

-Засгийн газар Холбооны Улсын засгийн газарт муж Улсуудын ЗГ-тай харьцуулахад илүү эрх мэдэл олгох хуулийн төсөл боловсруулав. Шинэ хуулийн дагуу Эрүүл мэндийн сайд нь Муж улсуудын хил нэвтрэхийг хориглох, халдвар авсан хүний харилцсан замналыг тогтоох, мөн эмч, эмнэлзүйн оюутан болон эмнэлгийн ажилтнуудыг халдварт өвчинтэй тэмцэх ажилд дайчлах эрхтэй болно.

2020-03-22

-Засгийн газар болон холбооны улсууд 2-оос дээш хүн цугларах, олон нийтийн газарт хүнээс 1.5 метрийн зай барих (гэр бүл, хамтран амьдрагч болон нэг гэрт амьдардаг хүмүүст хамаарахгүй) асуудлаар зөвшилцөлд хүрэв.

-Ресторан болон үсчин зэрэг нийтийн ахуйн үйлчилгээний газруудыг хаав.

**Эдийн засгийн
нөлөөллийг
бууруулах
чиглэлээр авч
хэрэгжүүлж байгаа
арга хэмжээ**

2020.03.13

- ЕХ руу Германаас гарах экспортыг хөнгөвчлөхөө мэдэгдэв. Засгийн газар хямралд өртөөд байгаа урлаг, уран сайхан, соёлын байгууллагууд болон том арга хэмжээ зохион байгуулагч компаниудад санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр болов.

- Хувийн бүх компаниудад хүссэн хэмжээгээр нь хязгааргүй зээл олгохоо амлав.

- Герман 10 000 ш агааржуулагч сэнс захиалж авахаар шийдэв (энэ нь Италийнхаас 2 дахин их хэмжээ аж), энэ нь тухайн үйлдвэрийнх нь бүтэн жилийн үйлдвэрлэлийн хэмжээ юм.

2020.03.27

- Төсвийн тодотгол хийж, нийт 156 тэрбум евро зардал нэмж батлав.⁷ Үндсэн хуулинд төсвийн нэмэлт алдагдлыг ДНБ-ний 0.35%-иас хэтрүүлж болохгүй гэж заасан байдаг ч “онцгой нөхцөл байдал” гэдэг шалтгаанаар үүнийг батлав. Нэмэлт төсвөөр санхүүжүүлэх арга хэмжээнүүд:⁸

- Эрүүл мэндийн тоног төхөөрөмж, эмнэлгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, эрдэм шинжилгээ-судалгаа (вакцин)-ны зардал

- Ажлын байрыг хадгалах, ажилтнуудын цалин хөлсний нөхөн олговорт зориулан “цагийн ажил”-ыг өргөтгөх, хүүхэд асрах тэтгэмжийг нэмэгдүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг тэтгэх

- Ковид-19-д нэрвэгдсэн жижиг бизнес эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд 50 тэрбум еврогийн хэмжээнд буцалтгүй тусламж үзүүлэх. Түүнчлэн он дуустал татварын алданги тооцохгүй.

- KfW-Хөгжлийн банкны шугамаар төсвөөс гадуур 600 тэрбум евро (ДНБ-ний 25% нь 825 тэрбум евро) зээлийг том, дунд компаниудад олгоно. Түүнээс гадна муж улсууд 48 тэрбум евро шууд дэмжлэг үзүүлнэ. Муж улсын хэмжээнд 63 тэрбум евро зээл олгоно.

-
- 2020 оны дуустал хугацаанд үнэт цаас борлуулах замаар 120 тэрбум евро, мөн 2020 оноос 2021 оны 6 сарын хугацаанд нэмж 750 тэрбум евро хөрөнгө босгохоор төлөвлөж байна.
 - Банкуудад 2019, 2020 оны ногдол ашиг хуваарилахгүй байх буюу цар тахлын үед өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахгүй байх үүрэг өглөө.

Парламентаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хуулийн өөрчлөлт

2020.03.27⁶ Бундэстагийн хуралдааны дэгийн хуулинд 2020.09.30 хүртэл хүчин төгөлдөр үйлчлэх нэмэлт, өөрчлөлт оруулав. Үүнд:

- Чуулганд нийт гишүүдийн дөрөвний нэгээс илүү гишүүн оролцоход хүчинтэйд тооцно.
- Байнгын хорооны хуралд биеэр буюу цахимаар дөрөвний нэгээс илүү гишүүн оролцоход хүчинтэйд тооцно.
- Байнгын хорооны дарга хурлаас гадуур санал өгч болно. Түүнчлэн шийдвэр гаргах, санал өгөхөд цахим хэрэгсэл хэрэглэхийг зөвшөөрнө.
- Нийтийн хороотой хийх зөвлөлгөөн болон нээлттэй хэлэлцүүлгийг зөвхөн цахим хэрэгслээр олон нийтэд хүргэхийг зөвшөөрнө.
- Чуулганы хуралдаанаар зөвхөн яаралтай асуудлыг хэлэлцэхээр шийдвэрлэж, хөтөлбөрийг богиносгосон.

2020.03.27⁷ Хуулиар 3 долоо хоногийн хугацаанд дампуурал зарлах ёстой байдгийг болиулж ковидээс шалтгаалсан хүндрэлийн улмаас 2020.09.30 хүртэл хойшлуулав. Ийм арга хэмжээг 2002, 2013 болон 2016 онуудад тохиосон их үерийн үед авч хэрэгжүүлж байсан туршлага бий.

- Халдвараас хамгаалах тухай хуулинд өөрчлөлт оруулж, цар тахлын үед Холбооны Улсад эрх мэдлийг илүүтэй төвлөрүүлэв. ХУ-ын Эрүүл мэндийн яам эм, эмнэлгийн материал татан авах, хүний нөөцийг хуваарилах зэрэгт шууд эрх мэдэлтэй болов. Түүнчлэн Герман улс руу нэвтрэхэд эрүүл мэндийн үзлэгт хамруулахаар болов.
 - Нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээний хязгаарлалтуудыг зөөллөв. Жишээлбэл: үл хөдлөх хөрөнгө, орон байрны болон халаалтын зардлын түвшингийн хяналт шалгалтыг 3-р сарын 1-нээс эхлэн 4 сарын турш хялбаршуулав.
 - Цагийн ажлаар олсон хөлсөнд тодорхой хугацаанд НДШ төлөхгүй болгов.
 - Улирлын чанартай ажил, ялангуяа хөдөө аж ахуйн салбарт богино хугацааны (түр) ажлын хугацааг 5 сар буюу 115 өдөр болгож уртасгав.
 - Нийгмийн ажилтнуудын ажлын байрыг 9 сарын 30 хүртэл заавал хадгалахыг ажил олгогч нарт үүрэг болгов.
 - Хөдөлмөрийн тухай хуулинд өөрчлөлт оруулж, ажлын цагийг ягштал баримтлахгүй байх боломжтой болгов.
-

- Чухал шаардлагатай мэргэжлийн тэтгэвэртээ гарсан өндөр настнуудын эргээд хөдөлмөр эрхлэлтийн хөлсний дээд хэмжээ 6 300 евро байсныг 44 590 евро болгож өсгөв. Энэ 2020 оныг дуустал мөрдөгдөнө.
- Түрээслэгч 2 сар төлбөрөө төлөөгүй бол түрээслүүлэгч гэрээгээ цуцалдаг байсан бол 4 сарын 1-нээс 6 сарын 30-ны хооронд гэрээг цуцалж болохгүй болгов. Түүнчлэн хэрэглээний зээлийн эргэн төлөлтөнд 2020.06.30 хүртэл хойшлуулах ба алданги тооцохгүй.
- Хүүхдийн мөнгө (хамгийн ихдээ сард 185 евро) олгоход эцэг, эхийн өнгөрсөн 6 сарын цалинг шалгадаг байсан бол сүүлийн 1 сарын цалингаар баталгаажуулж хүсэлт гаргах боломжтой болов. Үүнийгээ нэг удаа сунгуулах эрхтэй.
- Халдвараас хамгаалах хуулинд өөрчлөлт оруулж, хүүхдээ өөрөө асрахаас өөр боломжгүй бол 6 долоо хоног хүртэлх хугацаагаар цалингийнхаа 67%-тай тэнцэх нөхөн олговор авна.
- Эрүүгийн процессын хуулиар мөрдөн байцаах ажиллагаа 3 долоо хоног хүртэл завсарлаж болдог бол цар тахлын үед 3 сар 10 хоногийн хугацаагаар завсарлаж болно.
- Засгийн газраас шийдсэнчлэн, 5 хүртэл ажилтантай жижиг бизнес эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, чөлөөт уран бүтээлчид ямар ч хүнд сурталгүйгээр нэн даруй 9 000 евро, хэрэв 10 хүртэл ажилтантай бол 15 000 евро буцалтгүй тусламж олгоно. Энэ мөнгө нь төлбөрийн чадвараа алдахгүй байж, түрээс, зээлийн төлбөр, лийзинг зэрэг зардлуудыг нөхөхөд зориулсан юм.

7.БНСУ

БНСУ	
Өнөөгийн нөхцөл байдал	Коронавирусын тохиолдлын тоо: 10,423 Нас барсан: 204 Эмчлэгдсэн: 6,973 Анхны тохиолдол: 2 дугаар сарын 21
Батлагдсан хууль тогтоомжийн нэр, огноо	2020.02.26 Үндэсний Ассамблей эрх баригч болон сөрөг хүчний гишүүдээс бүрдсэн Корона вирустай тэмцэх арга хэмжээ авах онцгой албаны байнгын хороог байгуулсан. 2020.02.26 Дараах хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан. <i>1. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт²⁴</i>

²⁴ https://korea.assembly.go.kr:447/res/tra_read.jsp

-
- 2.Хорио цээрийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт²⁵
3.Эмнэлгийн үйлчилгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт²⁶
4.Цагаачлалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт (2020.03.05)²⁷

2020.03.18

Коронавирустэй тэмцэх үндэсний хэмжээний тэмцлийг дэмжих нэмэлт төсөв 11.7 их наяд вонын төсвийг баталсан.

Эрүүл мэндийн цогц арга хэмжээ

Нэмэлт төсвийн хуулиар **Халдварт өвчний хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэх** зорилгоор төсвийг 0.15 их наяд воноор дараах арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхээр тусгасан байна.Үүнд:

- Маск үйлдвэрлэх, нийлүүлэх
- Эмнэлгийн орны тоог нэмэгдүүлэх
- Эмчилгээний хөгжүүлэлтэд
- Эмнэлгийн ажилтнуудын нэмэлт дэмжлэг (коронавирусний улмаас орон нутагт ажилласан эмнэлгийн ажилтнуудын дэмжлэг)

Эдийн засгийн хариу арга хэмжээ

2020.03.18

- Үндэсний Ассамблей коронавирусний тархалтаас үүдэлтэй сөрөг нөлөөнөөс эдийн засгаа хамгаалах, халдварт өвчинтэй тэмцэх зорилгоор 11.7 их наяд вон буюу 9.4 тэрбум долларын төсвийг нэмж баталлаа.

Нийгмийн халамж, хамгааллыг дэмжих арга хэмжээ

Нэмэлт төсвийн хуулиар **Ард иргэдийн амьдралын тогтвортой байдлыг хангах** зорилгоор төсвийг 0.8 их наяд воноор нэмэгдүүлж дараах арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Бага орлоготой өрхөд хэрэглээний купон олгох
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- Бага орлоготой өрхүүдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бууруулах
- НӨАТ-ыг бууруулах
- Бага орлоготой ажилчдад халамж дэмжлэг үзүүлэх
- Цэцэрлэгийн үйл ажиллагаанд хязгаарлагдмал дэмжлэг үзүүлэх (хувийн цэцэрлэгийн үйл ажиллагааны тодорхой хэсэгт тусламж үзүүлэх)
- Цахим хичээлийн хүрээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх гэх мэт.

²⁵ https://korea.assembly.go.kr:447/res/tra_read.jsp БНСУ-ын Үндэсний Ассамблейн цахим хуудас

²⁶ https://korea.assembly.go.kr:447/res/tra_read.jsp БНСУ-ын Үндэсний Ассамблейн цахим хуудас

²⁷ https://korea.assembly.go.kr:447/res/tra_read.jsp БНСУ-ын Үндэсний Ассамблейн цахим хуудас

<p>Хариуцлагыг чангатгах чиглэлээр авч буй арга хэмжээ</p>	<p>Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт</p> <ul style="list-style-type: none"> • Халдварт өвчний дэгдэлтийн яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар • 1-р зэргийн халдварт өвчний дэгдэлт нь эм, ариун цэврийн хэрэглэл ба бусад бүтээгдэхүүний үнэ мэдэгдэхүйц өсөх, нийлүүлэлтийн хомсдолд хүргэх тохиолдолд Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд нь дээрх бүтээгдэхүүнийг тус улсаас тодорхой хугацаанд экспортлох, гаргахыг хориглож болно. Хоригийг зөрчсөн тохиолдолд таван жилээс хэтрэхгүй хугацаагаар хорих, эсвэл 50 сая вон хүртэл торгууль ногдуулж болно. • Сэжигтэй өвчтөн эрүүл мэндийн үзлэг, мөрдөн байцаалтад хамрагдаж халдвар авсан нь тогтоогдсон бол эмнэлэгт тусгаарлана. Энэхүү арга хэмжээг дагаж мөрдөөгүй бол нэг жил хүртэл хугацаагаар хорих, эсвэл 10 сая воноор торгох ялаар шийтгэж болно. <p>Эмнэлгийн үйлчилгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт</p> <p>- халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн хэн ч бай шинжилгээ өгөхөөс татгалзвал тухайн иргэнийг 3 сая вон хүртэлх торгууль ногдуулах, эсвэл хорих ялаар шийтгэхээр заасан.</p>
<p>Бусад (Тухайлбал, Сонгууль зохион байгуулах)</p>	<p>Цагаачлалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт (2020.03.05)</p> <p>Тус нэмэлт, өөрчлөлтөөр БНСУ оршин суух болон ажиллах зөвшөөрөлгүй гадаадын иргэний ажиллуулсан бол 30 сая вонын торгууль ногдуулах, эсвэл хорих ялаар шийтгэх, мөн тус улсад ажиллаж буй ажилтан, түүний төлөөлөгч Хууль зүйн сайдын зөвшөөрөлгүйгээр ажлын байраа өөрчилсөн бол 10 сая воноор торгохоор заасан. Энэхүү захиргааны шийтгэлийг хууль зүйн сайд чөлөөлөх буюу хүчингүй болгох эрхийг өгсөн.</p> <p>4 дүгээр сарын 15-ны өдөр Парламентын ээлжит сонгуультай. Энэ удаагийн сонгууль шинэ системээр явагдаж байна. 253 гишүүн нь нэг мандаттай мажоритар, 47 гишүүн нь намын жагсаалт бүхий пропорциональ системээр явагдана.</p> <p>СЕХ дэлхий нийтээр Covid 19 тахалтай холбогдуулан нийт сонгогчдын тоог 43,320 гэж үзэн хамгийн багадаа 58 хувийн ирцийг бүрдүүлэх 25 сая сонгогчдын маскийг бэлдэж өгөхийг Засгийн газраас хүссэн.</p> <p>Цар тахлын халдварыг сонгуулийн үеэр сонгууль өгөх байр дээр хүүхдүүд дагуулж ирэхгүй байх, ирэхийн өмнө 30 секундын турш гараа угааж ирэх, маск зүүхийг сануулж байна. Санал авах байрын үүдэнд иргэдийн халуун шалгаж оруулах бөгөөд гарыг ариутгасны дараа нэг удаагийн бээлий өгнө. Сонгогчид санал өгөхөөр дараалалд зогсохдоо нэг метрийн зайтай хүлээх, хоорондоо ярихгүй байх, дэлгэцэнд нүүрээ таниулах үед маскаа буулгаад буцаад зүүх, гэртээ очоод 30 секундын турш гараа угаах гэх мэтээр зөвлөмж өгч байна.</p>

8.Итали

Эх сурвалж:

- Италийн Засгийн газар -<http://www.governo.it/it/approfondimento/coronavirus/13968>
- Италийн эрүүл мэндийн яам-<http://www.salute.gov.it/nuovocoronavirus>
-

Итали	
Нөхцөл байдал	<p>2020.04.10, 11:00 цагийн байдлаар: Нийт тохиолдол – 143,626 Нийт нас барсан тохиолдол 18279 Нийт эдгэрсэн- 28470</p>
Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээнүүд²⁸	<p>Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) нь 2020 оны 1 дүгээр сарын 30-ний өдөр Хятад дахь коронавирусын дэгдэлт тархалтыг олон улсад нөлөөлж болзошгүй нийтийн эрүүл мэндийн онцгой нөхцөл байдал гэж зарласан. Үүнээс нэг өдрийн хойно Италийн засгийн газар нь 1-р сарын 22-наас эхлэн авч хэрэгжүүлж байсан <i>анхны урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ өөрчилж</i>, халдварын тархалтын өргөн цар хүрээт шинж чанарыг харгалзан онц байдал зарлаж, улсыг бүх газар нутгийн хэмжээнд халдварыг тогтоон, зогсоох анхны арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлсэн. Итали улсад Covid-19 өвчний анхны тохиолдлууд бүртгэгдсэн 2020 оны 1 дүгээр сарын 30-ний өдрөөс эхлээд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> • 2020.01.30. Эрүүл мэндийн яамны тушаалаар: <ul style="list-style-type: none"> - ЭМЯ-нд ажлын хэсэг байгуулж, ОУ-ын холбогдох байгууллагуудтай байнгын харилцаатай байж урьдчилсан сэргийлэх ажлыг зохион байгуулав. Энэ хүрээнд Хятадын талаас нислэгийг түр зогсоосон хэдий ч Хятад руу явах болон Хятадаас ирэх бүх нислэг, мөн Үхань хот руу болон Уханиас ирэх нислэгийг Итали улсын зүгээс нөхцөл байдлыг хянах, урьдчилан сэргийлэх ажлуудыг Олон улсын өндөр түвшинд авч хэрэгжүүлэхээр болжээ. • 2020.01.31. Сайд нарын Зөвлөлийн хуралдаанаар: <ul style="list-style-type: none"> - ДЭМБ-аас тунхагласан “Олон улсын нийтийн эрүүл мэндийн онцгой нөхцөл”-ийг дагалдан урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх онцгой нөхцөл байдлыг хууль ёсоор 6 сарын хугацаанд тогтоож, нийгмийн хамгааллын энэхүү шаардлагыг хангахад шаардагдах төсвийн санг баталсан. - Итали Хятадын хоорон дахь нислэгийг түр зогсоосон. • 2020.02.01. Үйл ажиллагааны хорооны хуралдаанаар: <ul style="list-style-type: none"> - Вирусын тархалтын тухайн үеийн нөхцөл байдалтай уялдсан үйл ажиллагааг дүгнэн түр хугацаагаар агаарын болон усан замын хөдөлгөөнтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг боловсруулж бэлтгэх тухай хэлэлцэв.

²⁸ <http://www.governo.it/it/articolo/coronavirus-conte-firma-il-dpcm-11-marzo-2020/14299>.

-
- Хятадтай нислэг түр зогсоосны дараа Эрүүл мэндийн болон Дэд бүтцийн яамдууд хамтран Гамшигтай тэмцэх нэгжийн дэргэд “Тусгай үйл ажиллагааны нэгж” байгуулж, Хятад дахь италичууд, Итали дахь хятадуудтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, ачаа тээвэр зохицуулах шийдвэр гаргав.
 - **2020.02.04-ний Эрүүл мэндийн яамны ажлын хэсгийн хуралдаанаар:**
 - Нийгмийн хамгааллын газартай хамтран бүх нисэх буудал, боомтын эрүүл мэндийн хяналт үзлэгийг эрс сайжруулах шийдвэр гаргав. Энэ хүрээнд Ром хотод гаднаас ирж буй бүх хөдөлгөөнд эрүүл мэндийн хяналтын коридор, халуун хэмжигч скайнер ажиллуулж эхэлсэн.
 - **2020.02.07-ны Эрүүл мэндийн яамны ажлын хэсгийн хуралдаанаар:**
 - Итали Хятадын хоорондох нислэгийг түр зогсоосон шийдвэрийг үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзэв.
 - **2020.02.21-ний Эрүүл мэндийн яамны ажлын хэсгийн хуралдаанаар:**
 - Эрүүл мэндийн яамнаас №85/Covid-19 “Шинэ албан ёсны хөл хорионы арга хэмжээ ба идэвхтэй хяналт” зөвлөмж бүхий захирамжийг хэвлэн нийтлэв. Үүнд: шинжилгээний хариу эерэг гарсан хүмүүсийн ойрын хавьталд орогчид албан ёсоор хөл хорионд орох, ойрын 14 хоногт эрсдэлтэй бүсэд байсан хүмүүс гэртээ тусгаарлах, орон нутгийн захиргаанд үнэн зөв мэдээлэх үүрэгтэй талаар зөвлөсөн.
 - **2020.02.23-ны Эрүүл мэндийн яамны ажлын хэсгийн хуралдаан, Засгийн газрын хуралдаанаар:**
 - СнЗ-ийн ерөнхийлөгч, ерөнхий сайд Конте-ийн санаачилгаар Covid-19 өвчний тархалтыг зогсоон, удирдах шуурхай арга хэмжээ бүхий зарлиг батлав. Энд Ломбарди, Венето зэрэг халдварын өндөр тархалттай бүс нутгуудыг “Улаан бүс” хэмээн зарлав.
 - **2020.02.24-ний Засгийн газрын хуралдаанаар:**
 - Эдийн засаг ба санхүүгийн сайд Роберто Гуалтиери Улаан бүс хэмээгдэх хотуудад оршин суугч татвар төлөгчдийн үүргийн тухайд интервенц хийх шийдвэр гаргав.
 - **2020.02.25-ны СнЗ-ийн ерөнхийлөгчийн зарлиг:**
 - 2020.02.23-ны шуурхай арга хэмжээний зарлигт нэмэлт оруулав. Үүнд бүх төрлийн спортын үйл ажиллагаа, сургуулалт, сургууль болон дээд боловсролын үйл ажиллагаа, хорих ангиуд дахь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, жолооны шалгалтыг хэрхэн өгөх зохицуулалт, соёл ба аялал жуулчлалын үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар зохицуулсан.
 - **2020.02.28-ны СнЗ-ийн хуралдаанаар:**
 - Covid-19 амьдралын нөхцөл байдалтай холбоотой гэр бүл, ажилтнууд ба бизнесийг шуурхай дэмжих арга хэмжээний талаар зарлигийг батлав.
 - **2020.03.01-ний СнЗ-ийн хуралдаанаар:**
-

-
- Ерөнхий сайд Конте Covid-19-ын халдварын тархалтыг зогсоох, хянах талаар өмнө 2020.02.23-ны өдөр баталсан зарлигийг дахин шинэчлэн, интервенцийн ажлыг нэгдсэн байдлаар хийх зохицуулалтыг бий болгох үүднээс бүх нутаг дэвсгэрт урьчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зарлиг гаргав.
 - **2020.03.04-ний Засгийн газар, нийгмийн хамгааллын байгууллагууд, орон нутгийн захиргаадын хамтарсан хурлын шийдвэрээр:**
 - Ерөнхий сайд Конте, Боловсролын сайд Люсиа Аззолина нар Итали даяар боловсролын бүх үйл ажиллагааг 3.5-3.15-ныг хүртэл халдвараас сэргийлэх үүднээс түр зогсоох шийдвэрийг зарласан.
 - **2020.03.06-ны СнЗ-ийн хуралдаанаар:**
 - Covid-19 –ийн тархалттай тэмцэх шуурхай бөгөөд онцгой арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор шүүхийн үйл ажиллагаан дахь сөрөг үр дагаврыг арилгах, үндэсний эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах тухай зарлигийг батлав.
 - **2020.03.08-ны СнЗ-ийн хуралдаанаар:**
 - Ерөнхий сайд 2020 оны 3-р сарын 1-4-ний өдрийн тогтоолууд үр дүнгүй байгаа учраас дахин тогтоол гаргаж Ломбарди мужийн бүс болон бусад 14 мужийн нутаг дэвсгэр дэх (таван Эмилия-Ромагнагаас, таван нь Пьемонт, гурав нь Венецо, нэг нь Марчегээс) 16 сая хүнийг хамруулан хэсэгчлэн хатуу хөл хорио тогтоох шийдвэр гаргав.
 - Ерөнхий сайдын 2020 оны 3-р сарын 8-ны өдрийн зарлигтай холбогдуулан Дотоод хэргийн сайд Лусиана Ламоргезе "бэхэлсэн бүсэд хяналт тавих ажлыг гүйцэтгэх удирдамжийг батлав. Энэ хүрээнд онцын чухал шалтгаант ажил, эрүүл мэндийн асуудал зэргээс бусад тохиолдолд тус бүсээс гарах болон нэвтрэхийг хориглов.
 - Мөн бүх төрлийн иргэний ёслолын үйл ажиллагааг түр зогсоосон. Үүнд: оршуулгын зан үйл ч багтсан.
 - Бар цэнгээний газрууд үйлчлүүлэгч тус бүрийн хооронд 1 метрийн зайтай байх нөхцөлийг ханган оройн 18.00 цаг хүртэл ажиллаж болно.
 - Чийрэгжүүлэх газрууд, музей, усан сан, театрууд, бооцоот тоглоомын газруудыг хааж, спорт зааланд олноороо бэлтгэл хийхийг хориглосон.
 - **2020.03.11-ний СнЗ-ийн хуралдаанаар:**
 - **03 дугаар сарын 11-нээс** эхлэн Италийн бүх нутаг дэвсгэрт хорио, цээрийн дэглэм тогтоож урьд өмнө авсан арга хэмжээгээ улам бүр чангатгасан.²⁹
 - хүнс болон үндсэн хэрэгцээний барааны худалдаа, эм үйлдвэрлэл болон эмийн сангаас бусад бүх арилжаа болон жижиглэнгийн худалдааны газруудыг хаах шийдвэр гаргасан.
-

²⁹ <http://www.governo.it/it/approfondimento/coronavirus/13968>- Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

-
- Эрүүл мэндийн систем, иргэд, бизнесийн үйл ажиллагаанд өгч байгаа дэмжлэгийг улам бүр бэхжүүлж, иргэний хамгаалалт болон аюулгүй байдлын нөөц боломжийг нэмэгдүүлэх үүднээс 2020 онд цаашид өрийг хэрхэн зохицуулах талаар Парламентад тавьсан тайланг (3 дугаар сарын 5-нд баталсан) хэлэлцэж, Сайд нарын Зөвлөлийн №36 зарлигийг батлав. Танхимын захиргаанаас санал оруулсан нийт дүнг хэлэлцээд улсын төсвийн цэвэр тэнцэтгэлийг 2020 онд чадавхын хувьд 104.5 тэрбум еврогоор, бэлэн мөнгөний хувьд 154 тэрбум еврогоор, мөн төсөв олголтын чадавх болон бэлэн мөнгөний аль алины хувьд 25 тэрбум хүртэлх еврогоор тус тус өсгөх болов.
 - **2020.03.14-ний өдөр.** Ерөнхий сайд 2020.03.11-ний СнЗ-ийн хуралдаанаар хүнс болон үндсэн хэрэгцээний барааны худалдаа, эм үйлдвэрлэл болон эмийн сангаас бусад бүх арилжаа болон жижиглэнгийн худалдааны газруудыг хаах шийдвэр гаргасантай холбогдуулан Ерөнхий сайд Конте Италийн үйлдвэрчний эвлэл болон нийгмийн түншлэлийн байгууллагуудтай видео уулзалт хурал хийж ажилтнуудын ажлын байрны аюулгүй байдлыг хангах, зайнаас ажиллах нөхцөл бололцоогоор хангах, зайлшгүй тохиолдолд 1 метрээс ойргүй зайг барьж ажиллах, ажилтнуудын цалин хөлс, амралт, бусад нэмэгдлийг доголдолгүй олгох, үйл ажиллагааны онцгой горимд шилжих, урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааны санамжийг байнга түгээх, ажлын байранд томоор хүмүүст харагдах газарт байрлуулах зэрэг авах арга хэмжээний тухай протоколд гарын үсэг зурлаа.
 - **2020.03.16-ны Сайд нарын Зөвлөлийн хуралдаанаар:**
 - Covid 19 цар тахлын онц байдал зарласантай холбогдуулан Улсын эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлж, гэр бүл, ажилтан, бизнест эдийн засгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай тогтоол баталлаа. Уг тогтоолд:
 - ✓ Улсын эрүүл мэндийн систем, иргэний хамгаалалт ба онцгой байдлын ажилд оролцох бусад төрийн байгууллагуудыг санхүүжүүлэх ба бэхжүүлэх бусад арга хэмжээ;
 - ✓ Ажлын байр ба орлогыг хамгаалах үүднээс ажил эрхлэлт ба ажилчдыг дэмжих;
 - ✓ Банкны системээр ба төв даатгалын санг ашиглан гэр бүлийн, жижиг дунд үйлдвэрлэл, аж ахуй, бизнес эрхлэгчдийг кредит дэмжлэг үзүүлэх;
 - ✓ Татвар болон хувь хандив, бусад татварын үүргүүдтэй холбоотой төлбөрийн үүргийг түр зогсоох, ажлын байрны ариутгалд татварын урамшуулал олгох, ажил үйлчилгээгээ эрхэлж байгаа ажилтнуудад бонус шагналт олгох зэрэг үндсэн 4 чиглэл ба бусад салбаруудад авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдэд интервенц хийхээр болжээ.
 - **2020.03.19-нд Сайд нарын зөвлөлөөс** Иргэний хамгааллын яамтай зөвшилцөн бүх Италийн хэмжээнд гол шаардлагатай бүс нутгуудад ажиллах эмч нарын зорилтот хүчийг сайн дурын үндсэн дээр бүрдүүлэх шийдвэр гарган 2020.03.20-ны өдрөөс бүртгэж эхлэхээр болжээ. Эмч нарын бүрэлдэхүүн хамгийн ихдээ 300 байх ба тэд эрүүл мэндийн бүтцийг дэмжих чиглэлээр ажиллана.
 - **2020.03.20-нд Эрүүл мэндийн сайдын тушаалаар:**
-

- Цэцэрлэгт хүрээлэн, зуслангийн байшин, олон нийтийн амралт зугаалгын газрууд, тоглоомын талбайд олноор цугларч тоглох, зугаалахыг хориглох,
- мөн эмнэлэг, нисэх буудлын доторх хоолны газар, хүнсний худалдаанаас бусад энэ чиглэлийн үйл ажиллагаа, үйлчилгээг хаах,
- Зайлшгүй шаардлагатай зөвшөөрөгдсөн үйлдвэрлэл, үйлчилгээг наанадаж 1-1,5м-ийн зайтай байх нөхцөлийг бүрдүүлэх
- Амралтын болон түүний өмнөх ба дараах өдрүүдэд шалтгаангүй бол өөрийн гэрээс өөр газарт зорчих хөдөлгөөнийг тус тус хориглосон. Эдгээр нь 2020.03.21-03.25 хүртэл хүчинтэй.
- **2020.03.22-ны** Эрүүл мэндийн яам болон Дотоод хэргийн яамны хамтарсан тушаалаар Тусгай ажлын шаардлага болон эрүүл мэндийн шалтгаантайгаас бусад тохиолдолд нийтийн болон хувийн тээврийн хэрэгслээр зорчихыг хориглосон.
- **2020.03.22-ны** өдрийн СнЗ-ийн ерөнхийлөгчийн зарлигаар хүнсний дэлгүүр, эмийн сан, ахуйн хэрэглээний дэлгүүр болон зайлшгүй шаардлагатай үйлчилгээнээс бусад үйлдвэрлэл, үйлчилгээнүүдийг хаасан. Энэ нь 2020.03.23-наас 04.03-ныг хүртэл хүчинтэй.

Засгийн газраас баталсан авах арга хэмжээний тухай зарлигийг Парламентаас хуульчлан баталсан нь

Итали улсад Covid-19 өвчний анхны тохиолдлууд бүртгэгдсэн 2020 оны 1 дүгээр сарын 30-ний өдрөөс эхлээд өнөөг хүртэл 3 үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Тухайлбал,

1-р үе шат буюу Онцгой нөхцөл байдалд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь улсын иргэний хамгаалалтын системийг идэвхжүүлсэн:

- **2020.01.31. Сайд нарын Зөвлөлийн зарлиг №1:**
 - ДЭМБ-аас тунхагласан “Олон улсын нийтийн эрүүл мэндийн онцгой нөхцөл”-ийг дагалдан урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх онцгой нөхцөл байдлыг хууль ёсоор 6 сарын хугацаанд тогтоож, нийгмийн хамгааллын энэхүү шаардлагыг хангахад шаардагдах төсвийн санг баталсан.
 - Ийнхүү Италийн Үндсэн хуулийн 77-р зүйлд³⁰ заасанчлан Зарлигт онцгой байдлыг зарлаж холбогдох эрх бүхий байгууллагууд (СнЗ, яам, Онцгой байдлын газар...) онцгой арга хэмжээ авах, шийдвэр гаргах эрх үүссэн.

³⁰ <http://www.governo.it/it/costituzione-italiana/parte-seconda-ordinamento-della-repubblica/titolo-i-il-parlamento/2852>

Үндсэн хуулийн 77 дугаар зүйл.

Засгийн газар танхимын төлөөлөлгүйгээр хуулийн үнэ цэнэ бүхий тогтоол гаргаж чадахгүй.

Онцгой, яаралтай нөхцөл байдлын үед Засгийн газар хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу түр зуурын арга хэмжээ авбал авах тогтоолыг танхимаараа хэлэлцэн 5 хоногийн дотор гаргаж болно.

Уг тогтоолууд нийтлэгдсэнээс хойш 60 хоногийн дотор хууль тогтоомж болж өөрчлөгдөөгүй бол нийтлэгдсэн өдрөөсөө хүчин төгөлдөр байна.

-
- Бүс нутгийн захиргаадын гаргасан шийдвэр нь улсын чанартай хууль, журам, шийдвэртэй зөрчилдвөл түүнийг хүчингүй болгоно.
 - Онцгой нөхцөл байдалд авах арга хэмжээний шийдвэрийг зөрчсөн тохиолдолд дээд тал нь 3 сар хүртэл хорих, 206 еврогоор торгох зэрэг арга хэмжээтэй.
 - Итали Хятадын хоорон дахь нислэгийг түр зогсоосон.

2-р үе шат буюу Онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээг эрчимжүүлсэн:

Онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбоотой урьдчилан сэргийлэх арга хэмжээний зарлиг нь тодорхой үр дүнгүй ба нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан нөхцөл байдалд тохируулан дараах зарлиг-хуулийг батлан хэрэгжүүлсэн.

- **2020.02.23-ны Зарлиг-хууль №6:**

Энэхүү зарлиг-хуулинд Гэр бүл, ажилтнууд, ААН-үүдийн үйл ажиллагаа дэмжих, эрүүл мэндийн системийн зохицуулалтын талаар СнЗ-ийн ерөнхийлөгч, ерөнхий сайд Конте-ийн санаачилгаар дараах арга хэмжээнүүдийг тусгажээ:

- Covid-19 өвчний тархалтыг бууруулах, зогсоох, хянах, бүх төрлийн шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхийг холбогдох захиргаадад олгосон.
- Ломбарди, Венето зэрэг халдварын өндөр тархалттай бүс нутгуудыг “Улаан бүс” хэмээн зарлав.
- Тус хөл хорио тогтоосон бүс нутагт сургууль боловсролын үйл ажиллагааг тодорхойгүй хугацаагаар зогсоосон.
- Чухал хэрэглээт ажил үйлчилгээ, хүнсний дэлгүүр, шуудан, банк зэргээс бусад үйлчилгээний газруудын үйл ажиллагааг түр хаасан.
- Мөн өвчний шинж тэмдэг илэрсэн хүмүүстэй хавьтагч болсон хүмүүсийн хөл хориог чангатгасан.
- Онцгой нөхцөл байдалд тохируулан СнЗ-ийн ерөнхийлөгчийн батлах хүртэл яаралтай арга хэмжээг авах түр шийдвэрийг онцгой байдлыг зохицуулах байгууллагууд гаргаж болно. Энэ нь хөл хориог тогтоох хууль эрх зүйн үндэс болно.

- **2020.03.08-ны Зарлиг-хууль №11:**

- Ерөнхий сайд 2020 оны 3-р сарын 1-4-ний өдрийн тогтоолууд үр дүнгүй байгаа учраас дахин зарлиг гаргаж Ломбарди мужийн бүс болон бусад 14 мужийн нутаг дэвсгэр дэх (таван Эмилия-Ромагнагаас, таван нь Пьемонт, гурав нь Венецо, нэг нь Марчегээс) 16 сая хүнийг хамруулан хэсэгчлэн хатуу хөл хорио тогтоох шийдвэр гаргав.

Гэсэн хэдий ч танхимууд өөрчлөгдөөгүй тогтоолын үндсэн дээр үүссэн эрх зүйн харилцааг зохицуулж болно.

-
- Ерөнхий сайдын 2020 оны 3-р сарын 8-ны өдрийн зарлигтай холбогдуулан Дотоод хэргийн сайд Лусиана Ламоргезе "бэхэлсэн бүсэд хяналт тавих ажлыг гүйцэтгэх удирдамжийг батлав. Энэ хүрээнд онцын чухал шалтгаант ажил, эрүүл мэндийн асуудал зэргээс бусад тохиолдолд тус бүсээс гарах болон нэвтрэхийг хориглов.
 - Мөн бүх төрлийн иргэний ёслолын үйл ажиллагааг түр зогсоосон. Үүнд: оршуулгын зан үйл ч багтсан.
 - Бар цэнгээний газрууд үйлчлүүлэгч тус бүрийн хооронд 1 метрийн зайтай байх нөхцөлийг ханган оройн 18.00 цаг хүртэл ажиллаж болно.
 - Чийрэгжүүлэх газрууд, музей, усан сан, театрууд, бооцоот тоглоомын газруудыг хааж, спорт зааланд олноороо бэлтгэл хийхийг хориглосон.
- **2020.03.09-ний Зарлиг-хууль №13:**
 - 2020.03.08-ны өдрийн Зарлиг-хуулийн арга хэмжээг бүх нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэхээр ажиллахыг холбогдох байгууллагуудад үүрэг болгосон.
 - **2020.03.11-ний СнЗ-ийн зарлиг №14:**
 - **03 дугаар сарын 11-нээс** эхлэн Италийн **бүх нутаг дэвсгэрт хорио, цээрийн дэглэм тогтоож** урьд өмнө авсан арга хэмжээгээ улам бүр чангатгасан.³¹
 - хүнс болон үндсэн хэрэгцээний барааны худалдаа, эм үйлдвэрлэл болон эмийн сангаас бусад бүх арилжаа болон жижиглэнгийн худалдааны газруудыг хаах шийдвэр гаргасан.
 - Эрүүл мэндийн систем, иргэд, бизнесийн үйл ажиллагаанд өгч байгаа дэмжлэгийг улам бүр бэхжүүлж, иргэний хамгаалалт болон аюулгүй байдлын нөөц боломжийг нэмэгдүүлэх үүднээс 2020 онд цаашид өрийг хэрхэн зохицуулах талаар Парламентад тавьсан тайланг (3 дугаар сарын 5-нд баталсан) хэлэлцэж, Сайд нарын Зөвлөлийн №36 зарлигийг батлав. Танхимын захиргаанаас санал оруулсан нийт дүнг хэлэлцээд улсын төсвийн цэвэр тэнцэтгэлийг 2020 онд чадавхын хувьд 104.5 тэрбум еврогоор, бэлэн мөнгөний хувьд 154 тэрбум еврогоор, мөн төсөв олголтын чадавх болон бэлэн мөнгөний аль алины хувьд 25 тэрбум хүртэлх еврогоор тус тус өсгөх болов.

3-р үе шат буюу Италийг эмчлэх арга хэмжээг эрчимтэй авч эхэлсэн:

- **2020.03.17-ны Зарлиг-хууль №18:**
Улс даяар Covid 19 цар тахлын онц байдал зарласантай холбогдуулан Улсын эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлж, гэр бүл, ажилтан, бизнест эдийн засгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч

³¹ <http://www.governo.it/it/approfondimento/coronavirus/13968>- Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

хэрэгжүүлэх тухай (2020.02.23-ны Зарлиг-хууль №6) зарлигийг шинэчлэн баталлаа. Уг зарлиг-хуульд:

- Улсын эрүүл мэндийн систем, иргэний хамгаалалт ба онцгой байдлын ажилд оролцох бусад төрийн байгууллагуудыг санхүүжүүлэх ба бэхжүүлэх бусад арга хэмжээ;
- Ажлын байр ба орлогыг хамгаалах үүднээс ажил эрхлэлт ба ажилчдыг дэмжих;
- Банкны системээр ба төв даатгалын санг ашиглан гэр бүлийн, жижиг дунд үйлдвэрлэл, аж ахуй, бизнес эрхлэгчдийг кредит дэмжлэг үзүүлэх;
- Татвар болон хувь хандив, бусад татварын үүргүүдтэй холбоотой төлбөрийн үүргийг түр зогсоох, ажлын байрны ариутгалд татварын урамшуулал олгох, ажил үйлчилгээгээ эрхэлж байгаа ажилтнуудад бонус шагналт цалин олгох зэрэг үндсэн 4 чиглэл ба бусад салбаруудад авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдэд интервенц хийхээр болжээ.

Энэ нь 126 бүлэг, 60 хуудас бүхий томоохон зарлиг-хуулийг хэрэгжүүлэхэд 350 тэрбум еврогийн санхүүжилт шаардлагатай бөгөөд үүнийг төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан юм.

- **2020.03.25-ны Зарлиг-хууль №19:**

- Энэхүү зарлиг-хуульд өмнө гаргасан хорио цээрийн арга хэмжээг өргөжүүлэн хуулийн чадавхтай болгосон.

- **2020.04.06-ны Зарлиг-хууль №22:**

- COVID-19-ийн эпидемиологийн яаралтай тусламжийг авах арга хэмжээний зохицуулалтыг мөн өргөжүүлсэн.
- Боловсролын байгууллагын үйл ажиллагааг 2020.09.1 хүртэл зогсоосонтой холбогдуулан багш нарын ажил, амралт, их дээд, дунд сургуулийн элсэлтийн шалгалт, төгсөх шалгалтыг авах, зохион байгуулах, багш нарыг үнэлэх, тэдгээрийн цалин хөлстэй холбогдох арга хэмжээг нэмж зохицуулсан

**Шийдвэрийг
үндэслэн хэрэгжүүлж
буй зарим арга
хэмжээ³²**

Вирус тархахаас урьдчилан сэргийлэх, бууруулах талаарх гаргасан зөвлөмж:

- Нийтийг хамарсан бүхий л үйл ажиллагааг түр зогсоох;
- Вирус өндөр тархалттай бүс нутгийг хэсэгчлэн болон бүх газар нутгаар хөл хорио тогтоох;
- Хүмүүс олноор цугларсан газар, агааржуулалт тааруу газраас зайлсхийх;

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр авч буй зарим арга хэмжээ:

- Бүх боомт, нисэх буудал, хяналтын цэгүүдэд халуун хэмжигч скайнер, эрүүл мэндийн хяналтын коридорыг ажиллуулсан.
-

³² <http://www.governo.it/it/articolo/coronavirus-conte-firma-il-dpcm-11-marzo-2020/14299> - СнЗ-ийн 2020.03.11-ний тогтоол. “Covid-19 халдварын тархалтыг зогсоох урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай”

- ДЭМБ, мэргэжлийн байгууллагуудаас гаргасан зөвлөмжийг дагах.
- 2020.03.21-нд ОХУ-ын Ерөнхийлөгч Путин Италийн Ерөнхий сайд Контетай утсаар ярихдаа туслах санал тавьж Covid 19 эсрэг арга хэмжээнд халдваргүйжүүлэлт ариутгалын машин, төхөөрөмж, цэргийн эмнэлэг, вирус судлалын 100 орчим мэргэжилтнээс бүрдсэн 8 бригадыг илгээхээр болов.

Хилийн хяналт, зорчих хөдөлгөөний арга хэмжээ:

- Италийн Засгийн газрын болон Эрүүл мэндийн яамны ажлын хэсгийн хуралдаанаар Covid-19-ийн халдварын тархалтыг зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор 2020.01.31-нээс Итали Хятадын хооронд нислэгийг түр зогсоосон.
- Хятадтай нислэг түр зогсоосны дараа Эрүүл мэндийн болон Дэд бүтцийн яамдууд хамтран Гамшигтай тэмцэх нэгжийн дэргэд тусгай үйл ажиллагааны нэгж байгуулж, Хятад дахь италичууд, Итали дахь Хятадуудтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, ачаа тээвэр зохицуулах шийдвэр гаргасан.

9.БНКаз.У

Эх сурвалж:

- <https://primeminister.kz/kz/news/reviews/zhumyspen-kamtu-zhene-eleumettik-tolem-totenshe-zhagday-kezinde-memleket-kanday-sharalar-kabyldauda-73325>
- <https://www.gov.kz/memleket/entities/dsm/documents/details/25620?lang=ru>

Бүгд Найрамдах Казахстан Улс	
Өнөөгийн нөхцөл байдал	2020.04.10-ны өдрийн байдлаар: бүртгэгдсэн 802 , нас барсан 9 Нур-Султан, Алматы хотуудад байгууллага, ААН-ийн үйл ажиллагааг түр зогсоох шийдвэрийг 2020.04.13 хүртэл сунгасан. Шымкент хотод 2020.04.04-нээс хөл хорио тогтоосон.
Батлагдсан хууль тогтоомжийн нэр, огноо	Коронавирустай холбоотой шинээр баталсан хууль байхгүй. Засгийн газраас холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.
Эрүүл мэндийн цогц арга хэмжээ	Нур-Султан, Алматы, Шымкент хотуудад түргэн хугацаанд хялбар хурдан барих байгууламжийг ашиглаж халдварт өвчнийг эмчлэх эмнэлэг барих шийдвэр гарсан. Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд коронавирүсний халдварыг тодорхойлох тест гаргаж авсан.

Эдийн засгийн хариу арга хэмжээ	<p>Засгийн газрын шийдвэрээр барилгын салбарыг дэмжих болон иргэдийг ажлын байраар хангах зорилгоор Үндэсний банк 180 сая тенгенийнэмэлт санхүүжилт хуваарилсан.³³</p> <ul style="list-style-type: none"> – “Ажлын байраар хангах арга зам” төслийг хурдан хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ авч санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэсэн. Төслийг хэрэгжүүлснээр 240 мянган ажлын байр бий болгох боломжтой. – ААН-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор татварын хөнгөлөлт үзүүлэхээр болсон. Энэ нь эдийн засгийн төрөл бүрийг салбарыг хамрах бөгөөд ялангуяа, худалдаа, нийтийн хоолны үйлчилгээ, зочид буудал, аялал жуулчлал болон бусад үйлчилгээний салбарыг хамрах юм. – Онц нөхцөлд иргэд болон бизнесийн үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд 2020.03.16-06.15 хүртэл 3 сарын хугацаанд зээл болон төлбөр төлөлтийг түр зогсоох шийдвэр гарсан. Холбогдох хүсэлтийг цахимаар гаргах арга хэмжээ авч ажиллаж байна (Телеграм-бот аппликейшн).
Нийгмийн халамж, хамгааллыг дэмжих арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> – Коронавирусний өвчинтэй тэмцэж буй эмнэлэгийн ажилтнуудад нэмэгдэл цалин хөлс олгохоор болсон. Эмнэлэгийн ажилтан коронавирусний халдвар авч өвдсөн тохиолдолд 2 сая тенге, нас барсан тохиолдолд 10 сая тенге нийгмийн халамж олгоно. – Нийгмийн халамж авдаг хүний тоог нэмэгдүүлсэн бөгөөд ойролцоогоор Казахстаны 3 сая иргэнд (ажилгүй болсон, орлогын эх үүсвэргүй болсон гэх мэт) нөхөн төлбөр олгохоор болсон. <ul style="list-style-type: none"> ○ цалингүй амралт олгосон жижиг дунд үйлдвэрлэл бүхий байгууллагын ажилчид ○ цалингүй амралт олгосон хол хорио тогтоосон бүсэд үйл ажиллагаа явуулдаг томоохон бизнесийн байгууллагын ажилчид ○ хөлсний бус үйл ажиллагаа эрхэлдэг хувийн бизнес эрхлэгчид ○ хувиараа нотариат, өмгөөлөл, медиатор гэх мэт үйл ажиллагаа эрхлэгчид гэх мэт. – Олон хүүхэдтэй гэр бүл, ажилгүй иргэдэд хүнсний бүтээгдэхүүнийг үнэгүй өгөхөөр болсон. Холбогдох хүсэлтийг цахимаар гаргах арга хэмжээ авч ажиллаж байна (Телеграм-бот аппликейшн).

10.Япон

Эх сурвалж:

- Японы Засгийн газрын цахим хуудас, <https://japan.kantei.go.jp>
- Японы Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/newpage_00032.html

³³ <https://primeminister.kz/kz/news/v-2020-godu-arendnym-zhilem-planiruetsya-obespechit-12-600-semey-miir-rk-73241>
<https://primeminister.kz/kz/news/pravitelstvo-prinyalo-dopolnitelnye-mery-po-podderzhke-grazhdan-i-biznesa-231525>

Япон

Нөхцөл байдал 2020.04.07-нд Ерөнхий сайд Ш.Абе Токио, Осака, Сайтама, Канагава, Чiba, Хиого, Фүкүока зэрэг нийт 7 префектур (муж)-т 2020.05.06-хүртэл онц байдал зарласан.³⁴

2020.04.08, 12:00 цагийн байдлаар:³⁵

Нийт бүртгэгдсэн тохиолдол –4257

- Нас барсан хүний тоо – 81

Батлагдсан хууль тогтоомжийн нэр, огноо

Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт:

Онц байдал зарлах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлд 2012 онд батлагдсан “Шинэ төрлийн ханиад, томууны эсрэг тусгай арга хэмжээ авах тухай хууль” (新型インフルエンザ等対策特別措置法)³⁶-д нэмэлт, өөрчлөлт оруулж, 2020.03.14-ны өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн. Ингэснээр коронавирусын халдвар улс оронд хурдан тархаж, хүмүүсийн амьдрал, эдийн засагт ноцтой нөлөөлөх нөхцөл үүсэх бол Ерөнхий сайд онц байдлыг хоёр жил хүртэл хугацаагаар зарлах эрхтэй болж байгаа юм. Онц байдал зарлагдсаны дараа мужийн захирагчид оршин суугчдыг онц шаардлагагүй бол гэрээсээ гарахгүй байхыг хүсэх/шаардах, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоох, олон нийтийн арга хэмжээ цуцлах, хойшлуулах зэрэг эрхтэй болно (дагаж мөрдөөгүй тохиолдолд ямар нэгэн хуулийн хариуцлага хүлээлгэхгүй). Мөн орон нутгийн засаг захиргаа эм, хоол хүнс зэрэг зайлшгүй шаардлагатай материалыг тэдэнд зарахыг шаардаж болно. Тэд эмнэлгийн тусламж үзүүлэх зорилгоор хувийн газар, байгууламжийг түр хугацаагаар ашиглах, дайчлах эрхтэй болно.³⁷

Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээнүүд

Японы Засгийн газрын 2020.03.10-ны өдрийн хуралдаанаар:

2020.03.15-ны өдрөөс эхлэн амны хаалт дамлан худалдаалахыг (худалдаж авсан үнээс давуулж зарах) хориглож, зөрчсөн тохиолдолд 3 сая хүртэл иенийн (28.5 мянган ам.доллар) торгууль, эсхүл жил 5 хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар шийдвэрлэсэн.

2020.02.25-нд Шинэ коронавирусын халдварыг хянах төв штабаас:

“Basic Policies for Novel Coronavirus Disease Control”³⁸-ийг гаргасан. Энэхүү баримт бичиг нь одоо авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид үүсэх нөхцөл байдлын хариу арга хэмжээнүүдийг нэгтгэсэн баримт

³⁴ Японы Засгийн газрын цахим хуудас, <<https://japan.kantei.go.jp>> хандсан 2020.04.09

³⁵ Японы Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудас, <https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/newpage_00032.html> хандсан 2020.04.09

³⁶ Японы албан ёсны мэдээллийн цахим сан. Японы дотоод хэрэг, харилцаа холбооны яам.

<https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=424AC0000000031> хандсан 2020.04.09

³⁷ Японы Засгийн газрын цахим хуудас, <<https://japan.kantei.go.jp>> хандсан 2020.04.09

³⁸ <https://www.mhlw.go.jp/content/10200000/000603611.pdf>

бөгөөд өвчтөний өсөлтийн түвшинг бууруулах, тархалтыг багасгахын зэрэгцээ тархалтыг эрт зогсоох, хүнд тохиолдлуудыг багасгах, Японы нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг багасгахад чиглэгдэж байна.

/[COVID-19] Government Responses on the Coronavirus Disease 2019/ Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээ дараах гурван асуудалд чиглэгдэж байна.³⁹ Үүнд:

- **Ковид-19 халдварын PCR оношилгоо;**
 - **Сургуулиудын үйл ажиллагааг түр зогсоох;**
 - **Ахмад настнуудад зориулсан нийгмийн халамжийн байгууламжууд.**
1. Ковид-19 халдварын PCR оношилгоотой холбоотойгоор дараах арга хэмжээ авч ажиллаж байна. Шинжилгээ хийх хүчин чадлыг нэмэгдүүлсэн (өдөрт 6000-8000 хүргэх). Үүнд тусгаарлах төвүүд, улсын болон хувийн эрүүл мэндийн байгууллагууд, лабораториуд, Их дээд сургуулиуд орж байна. Эрүүл мэндийн байгууллагаас шинжилгээ өгөх шаардлагатай гэж үзсэн хүмүүс болон гадаадаас ирсэн, халдвартай иргэнтэй харьцсан байж болзошгүй иргэд 24 цагийн дуудлагын төвөөр дамжуулж захиалга өгч, улсын эрүүл мэндийн байгууллагад очихгүйгээр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад хандах боломжийг бүрдүүлсэн. PCR шинжилгээг эрүүл мэндийн даатгалд хамруулсан. Оношилгооны хугацааг богиносгох шинэ оношлуурыг боловсруулах.
 2. Хүүхдүүдийн дунд халдвар тархахаас урьдчилан сэргийлэхэд халдвар тархсан газраас гадна улс даяар халдварын эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах. Үүнтэй холбоотойгоор хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж бүх бага, дунд, ахлах болон бусад сургуулиудыг хаврын амралт хүртэл түр хугацаагаар хаасан. Харин ясли, цэцэрлэгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа ч тухайн байгууллагад хамрагдаж буй хүүхэд, ажиллаж буй ажилтнууд, эсхүл бусад хүмүүс коронавирусын халдвар авсан бол орон нутгийн засаг захиргаа, эсхүл холбогдох байгууллага халдвар ойр орчмын газарт тархаж байгааг тогтоосон тохиолдолд дээрх байгууллагын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож болно. Ийм нөхцөлд Засгийн газар хүүхдийг холбогдох ажилтнуудаар богино хугацаагаар гэрээр нь асруулах зэрэг арга хэмжээ авч болно.
 3. Хүнд хэлбэрийн шинж тэмдгүүд үүсэх эрсдэл нь өндөр настай хүмүүс болон суурь өвчтэй өвчтөнүүдэд өндөр байгааг харгалзан ахмад настны асрамжийн газар болон бусад байгууламжуудад халдварыг тархаагүй байхад онцгой анхаарч Засгийн газар нь орон нутгийн засаг захиргаатай хамтран урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, улсын хэмжээнд эдгээр байгууламжид анхаарлаа хандуулан ажиллаж байна.

³⁹ Мөн тэнд.

Засгийн газраас дээрх газруудад Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас гаргасан халдварын хяналтын заавар (холбогдох эрүүл ахуйн арга хэмжээ)-ыг хэрэгжүүлэхийг холбогдох газруудад уриалж, онц шаардлагатайгаас бусад тохиолдолд эргэлт, гаднаас хүн оруулахыг хязгаарлах, хүргэлтийн үйлчилгээг зөвхөн нэгдсэн цэгээр дамжуулан авах, гаднаас ирж буй хүний биеийн халууныг хэмжих, халуунтай бол оруулахгүй байх зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна.

Эдийн засгийн багц арга хэмжээ

The Second Novel Coronavirus Disease (COVID-19) Emergency Response Package - 2 дахь багц арга хэмжээ (2020.03.10-ны байдлаар)⁴⁰

- Засгийн газар халдвар тархахаас урьдчилан сэргийлэхийн тулд бүх хүчин чармайлтаа гаргаж, тулгамдсан асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх (**төсвийн арга хэмжээ: ойролцоогоор 400 тэрбум иен; санхүүгийн арга хэмжээ: нийт 1.6 их наяд иен**).
- Энэ нь тархвар судлалын нөхцөл байдлын хамт бүс нутгийн болон дэлхийн эдийн засгийн чиг хандлагыг сайтар хянаж, шаардлагатай арга хэмжээг авна.

(1) COVID-19-ийг тархахаас урьдчилан сэргийлэх, эмчилгээний барилга байгууламж, тогтолцоог бэхжүүлэх:

Халдвар тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

- Халдварын голомт үүсгэхгүй байх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах. Тархалтыг зогсоосноор шинээр нэмэгдэх халдварын тоог бууруулах;
- Орон нутгийн засаг захиргаанд “counter-cluster measures” халдварын голомтын эсрэг арга хэмжээ авах холбогдох экспертүүдийг илгээх;
- Асрамжийн газар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан байгууламж, ясли, цэцэрлэг болон бусад байгууллагад ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, хэрэгслийг худалдан авахад туслалцаа үзүүлэх.

Амны хаалтын эрэлт ба нийлүүлэлттэй холбоотой цогц арга хэмжээ:

Амны хаалтны хомсдолтой байгааг харгалзан эрэлт, нийлүүлэлтийн аль алинд нь чиглэсэн цогц арга хэмжээ авах.

- Амны хаалтыг цахимаар болон бусад аргаар дамлаж зарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор амны хаалтыг дамлаж худалдаалахыг хориглох;
- Засгийн газар 20 сая даавуун амны хаалтыг нэг дор худалдаж авч, асрамжийн газар болон бусад байгууламжуудад шуурхай тараах;

-
- Засгийн газар 15 сая мэс заслын амны хаалтыг нэг дор худалдаж авч, шаардлагатай эмнэлгийн байгууллагуудад нэн тэргүүний ээлжинд тараах;
 - Амны хаалт үйлдвэрлэгчдэд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

PCR скрининг (шуурхай үзлэг, оношилгоо) тогтолцоог сайжруулах:

- Скринингийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад PCR скрининг хийх төхөөрөмжийг суурилуулахад дэмжлэг үзүүлэх (өдөрт ойролцоогоор 7000 оношилгоо);
- PCR шинжилгээг эрүүл мэндийн даатгалд хамруулах.

Эмчилгээний системийг сайжруулах, эмчилгээг хурдасгах:

- Халдвар тархахаас урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ Засгийн газар өвчтөнүүдийн тоо ихсэхэд бэлтгэхийн тулд хүнд өвчтэй хүмүүсийг эмчилгээний тогтолцоог бэхжүүлнэ. Эмнэлгийн яаралтай тусламжийн 5,000 гаруй ор бэлдэх, респиратор (амьсгалын аппарат) зэрэг тоног төхөөрөмж суурилуулахад дэмжлэг үзүүлэх (зардлын тал хувийг төрөөс санхүүжүүлэх);
- Японы Эрүүл мэндийн судалгаа, хөгжлийн агентлаг (AMED)-ийн тусламжтайгаар вакцин болон бусад эмчилгээг гаргаж авах ажлыг хурдасгах.

Шинж тэмдэгтэй хүмүүст зориулсан арга хэмжээ:

Эрүүл мэндийн даатгалаас осол гэмтэл, өвчний тэтгэмжийг жигд олгоход Засгийн газраас өргөдөл гаргах процессын талаар мэдээлэх. Үүнд: халуурах шинж тэмдэг илэрч, өөрийгөө гэртээ тусгаарласан тохиолдлууд орно.

Олон нийтийн харилцааг бэхжүүлэх:

Засгийн газар Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын олон нийттэй харилцах харилцаа албаны цахим хуудас болон бусад хэрэгслээр дамжуулан компаниуд, орон нутгийн засаг захиргаа зэрэг бүхий л байгууллагуудад гол чухал мэдээллийг дамжуулна. Гол чухал мэдээлэлд COVID-19 өвчний дэгдэлтийн байдал, гар угаах гэх мэт халдвараас урьдчилан сэргийлэх арга зам, эмнэлзүйн мэдээ, эмнэлгийн зөвлөгөө, шинжилгээ хийх тогтолцоо, тусламж үйлчилгээ үзүүлж буй эмнэлгийн байгууллагуудын талаарх мэдээлэл зэрэг орно.

(2) Сургуулиудыг түр хаасантай холбоотойгоор авах арга хэмжээ:

Ажлаас чөлөө авах:

Сургуулиудыг түр хаасантай холбоотойгоор эцэг эхчүүдэд ямарваа нэгэн хүндрэлгүйгээр ажлаас чөлөө авах боломжийг бүрдүүлэхэд чөлөө авах шаардлага үүссэн эцэг эхчүүд болон чөлөө авах шаардлагатай ажилтан ажиллуулж буй бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.

- Ажилчдын орон тооны, орон тооны бус зэргээс үл хамааран татаас өгөх шинэ тогтолцоог бий болгох (өдөрт 8,330 иен хүртэл);
- Туслан гүйцэтгэгчээр ажилладаг болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих (тодорхой шаардлага хангасан хүмүүст өдөрт 4,100 иен олгох).

Яаралтай тусламжийн жижиг сангаас тусгай зээл олгох:

Засгийн газраас амьжиргааны болон нийгмийн халамжийн сангийн зээлийн хөтөлбөрөөс COVID-19-ийн нөлөөллөөс болж орлого нь буурч буй өрхүүдэд тусгай үйлчилгээ үзүүлэх.

- Яаралтай тусламжийн жижиг сангаас тусгай зээл олгох (яаралтай тусламжийн жижиг зээлийн хэмжээ: 100,000-200,000 иен хүртэлх хүүгүй зээл, тэглэх боломжтой).

Хичээлээс гадуурх үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлэх:

Хүүхдүүдийг очих газартай болгохын тулд төр засгийн зүгээс хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эцэг эхийн эдийн засгийн ачааллыг багасгахад шаардлагатай дэмжлэгийг үзүүлнэ.

- Хичээлийн дараах клубуудыг өглөөнөөс ажиллуулахтай холбоотой нэмэлт зардлыг Засгийн газраас санхүүжүүлэх.
- Гэр бүлийг дэмжих төвийн үйлчилгээний төлбөрийг бууруулах, чөлөөлөх зардлыг Засгийн газраас санхүүжүүлэх.
- Хувийн хэвшлийн нялх хүүхэд асрах үйлчилгээ хэрэглэгчдийн хөнгөлөлтийн ваучерын хэмжээг нэмэгдүүлэх (сард 24 ваучераас 120 ваучер хүртэл).

Сургуулиудын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотой сургуулийн үдийн хоолны зардал:

- Сургуулиудын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотойгоор эцэг эхчүүд сургуулийн үдийн хоолны төлбөрийг 2020.03.02-ноос хаврын амралт хүртэлх хугацаанд төлөхгүй.
- Сургуулийн хоолны төлбөрийг эцэг эхчүүдэд буцаан олгох, холбогдох зардалд дэмжлэг үзүүлэх.
- Сургуулийн хоол үйлдвэрлэгч, хоол хүнс нийлүүлэгч, сүүний фермүүд зэрэг оролцогч талуудад зохих дэмжлэг үзүүлэх.

Зайнаас ажиллахыг хөхиүлэн дэмжих:

Сургуулиудын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотойгоор эцэг эхчүүд гэрээсээ ажиллах нь нэмэгдэх төлөвтэйг харгалзан, мөн өвчин болон халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор ажилтнуудыг зайнаас ажиллахыг идэвхтэй уриалах.

(3) Бизнесийн үйл ажиллагаа, ажил эрхлэлт хумигдсантай холбоотой авах арга хэмжээ:

Хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах татаас олгох тусгай арга хэмжээг өргөжүүлэх:

- COVID-19-ээс үүдэн хүмүүс, бараа бүтээгдэхүүний урсгалыг буурч байгаатай холбоотойгоор зарим ААН-үүд үйл ажиллагаагаа зогсооход хүрч байна. Ийм нөхцөлд Засгийн газраас ажлын байрыг хадгалах, хүмүүсийн амьдралын тогтвортой байдлыг хангах үүднээс хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах татаасыг нэмэгдүүлэх онцгой арга хэмжээг өргөжүүлнэ. Тусгай арга хэмжээний хамрах хүрээг өргөжүүлж бүх бизнес эрхлэгчдийг хамруулах, хамрагдах шалгуурыг тодорхой болгож, зохицуулалтыг 2020 оны 1-р сараас тооцон буцаан хэрэглэх.
- Тодорхой салбаруудад татаас олгох хэмжээг нэмэгдүүлэх (Жижиг, дунд үйлдвэрлэлд: 2/3-аас 4/5 хүртэл нэмэгдүүлэх; томоохон аж ахуйн нэгжүүдэд: 1/2-ээс 2/3 хүртэл)

Хөрвөх чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх:

- ААН тэр дундаа олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахаас татгалзаж буй байгууллагууд болон халдварыг хяналтад авсны дараах бизнесийн өсөлтийг хангахын тулд Засгийн газар Японы Санхүүгийн корпораци болон бусад институцээс нийт 1,6 их наяд иений санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Ингэхдээ анхаарлыг нэн түрүүнд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд чиглүүлнэ.
- COVID-19 тусгай зээлийн хөтөлбөрийг (500 тэрбум иенийн хэмжээтэй) бий болгож, зээлийн хүүг бууруулах, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч болон бусад хүмүүст бодит хүүгүй, баталгаа шаардахгүй санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх.
 - Хямралын эсрэг хариу арга хэмжээ авах зорилгоор дотоодын хангамжийн сүлжээг санхүүжүүлэх, өөрчлөн байгуулах ажлыг Японы Хөгжлийн банк (DBJ), Шоко Чукин банк (204 тэрбум иений хүрээнд)-аар дамжуулан дэмжих.
 - Хувийн санхүүгийн байгууллагуудыг шинэ зээлийг идэвхтэй олгох, авсан зээлийн нөхцөлийг өөрчлөхийг уриалах.

Нийлүүлэлтийн сүлжээнд учирсан хохирлын эсрэг арга хэмжээ:

- Японы Олон улсын хамтын ажиллагааны банк (JBIC)-ы Өсөлтийн хөрөнгө оруулалтын байгууламж (Growth investment facility) ба бусад арга хэмжээг ашиглах (500 тэрбум иен хүртэл).
- DBJ-ээр дамжуулан дотоодын хангамжийн сүлжээг дахин зохион байгуулахыг дэмжих (дээрхтэй ижил арга хэмжээ авах).

Аялал жуулчлалын салбартай холбоотой арга хэмжээ:

Халдвар тархахаас урьдчилан сэргийлэх нь аялал жуулчлалын эрэлт сэргэх үндэс суурь юм. Одоогийн байдлаар Хөдөлмөр эрхлэлтийн зохицуулалтын татаас, хөрвөх чадварыг дэмжих замаар Засгийн газар аялал жуулчлалын салбарыг дэмжинэ.

- Үзвэр, үйлчилгээ, аяллын газруудыг төрөлжүүлэх, үүнд сонирхол татахуйц аялал жуулчлалын агуулгыг боловсруулах, тэмдэг, тэмдэглэгээг олон хэл дээр бэлдэх зэргээр дэмжлэг үзүүлэх.
- Төрийн болон хувийн хэвшилтэй хамтран COVID-19-ийн дараах кампанит ажил явуулах асуудлыг судлах.

(4) Нөхцөл байдлын байдалд дасан зохицох яаралтай арга хэмжээ:

Хуулийн төсөл боловсруулах (Батлагдсан):

“Шинэ төрлийн ханиад, томууны эсрэг тусгай арга хэмжээ авах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах (Засгийн газрын 2020 оны 3-р сарын 10-ны өдрийн шийдвэр).

Хилийн хяналтын арга хэмжээ:

Халдвартай хүмүүс их хэмжээгээр Япон руу нэвтрэхээс урьдчилан сэргийлэх үүднээс Засгийн газар одоо байгаа хилийн хяналтын арга хэмжээг үргэлжлүүлэх, түүний дотор аяллын зөвлөмжид заасан хязгаарлалтыг хэрэгжүүлэх. Шуурхай, уян хатан хариу арга хэмжээ авах, үүнд хилээр нэвтрүүлэхээс татгалзах, визийн хязгаарлалт, хорио цээрийн арга хэмжээг чангатгах, өвчний эрсдэлийн талаар мэдээлэл түгээх зэрэг арга хэмжээ авах.

Захиргааны журам ба төрийн худалдан авалттай холбоотой түр арга хэмжээ:

Халдвар тархахаас урьдчилан сэргийлэх шаардлагын харгалзан Засгийн газраас захиргааны журам, төрийн худалдан авалт болон бусад үйл ажиллагаатай холбоотой асуудалд уян хатан хандах.

- Татварын тайлангийн хугацааг 2020 оны 4-р сарын 16 хүртэл сунгах, жолооны үнэмлэхийг сунгуулахтай холбоотой түр арга хэмжээ.
- Үндэсний татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийн тогтолцоог идэвхтэй сурталчилж, хурдан, уян хатан хариу арга хэмжээ авах.
- Төрийн барилга угсралтын ажилд уян хатан хандах (барилгын хугацааг сунгах гм.)

Олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх:

- Засгийн газар нь COVID-19-ийн тархалтад өртсөн хөгжиж буй орнуудын халдварын эсрэг тэмцэлд идэвхтэй хувь нэмэр оруулах. ДЭМБ болон бусад байгууллагуудаас үзүүлж буй яаралтай тусламжид хувь нэмэр оруулах.

Орон нутгийн засаг захиргааны хүчин чармайлтад төсвийн дэмжлэг үзүүлэх

11.Бахрейн

Эх сурвалж:

<https://www.ipu.org/parliaments-in-time-pandemic>

Бахрейн	
Нөхцөл байдал	2020.04.09, 21:00 цагийн байдлаар: ⁴¹ Нийт бүртгэгдсэн тохиолдол –723 (шинжилгээнд хамрагдсан - 55096) Нас барсан хүний тоо – 5
Парламентын ажиллагаа	Бахрейны Аль-Ватани (Үндэсний Ассамблей) нь чуулганыхаа нэгдсэн хуралдааныг хэвийн явуулж байгаа бол бусад хороод алсын зайнаас хуралдаж байна.
Батлагдсан хууль тогтоомжийн нэр, огноо	Бахрейны хууль тогтоох байгууллага нь COVID-19 тахлын үед иргэдийн аюулгүй байдлыг хангах, тахлын үр дагаврыг арилгах Засгийн газрын эдийн засаг, санхүүгийн багц хуулийг хэрэгжүүлэх Зорилгоор засгийн газартай хамтран ажиллаж байна. Хувийн хэвшлийн ажилчдын цалинг 4, 5, 6-р саруудад олгохыг зөвшөөрсөн хуулийн төслийг хэлэлцэж байна. ⁴²
Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээ⁴³	<p>Засгийн газраас хувь хүн, компаниудад дэмжлэг олгоход 11.4 тэрбум ам.доллар зарцуулахаар төлөвлөсөн. Хуулийн төсөл батлагдсан тохиолдолд зээлийн хүүг бууруулах, зээлийн бүтцийн өөрчлөлт, цалингийн дэмжлэг, түрээсийг бууруулах, бизнес эрхлэгчдэд татаас олгох, нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөх зэрэг арга хэмжээ, дэмжлэг, хөнгөлөлтийг 6 сарын турш үзүүлэх юм.</p> <p>Засгийн газраас сургалтыг алсын зайнаас явуулах; хэсэгчилсэн комендантын цаг тогтоох; цахим засгийн газрын үйлчилгээг сайжруулах; коронавирусын фронтын шугаманд ажиллаж буй ажилтнууд болон сайн дурын ажилтнуудад урамшуулал олгох; дунд, жижиг, бичил хувийн хэвшлийн компани, байгууллагуудад санхүүгийн тусламж үзүүлэх, эмэгтэй ажилтнуудыг алсын зайнаас ажиллуулах зэрэг арга хэмжээ авч байна.</p>

⁴¹ Бахрейны Эрүүл мэндийн яамны цахим хуудас, <<https://www.moh.gov.bh/?lang=en>>х андсан 2020.04.09

⁴² Бахрейны Эдийн засгийн хөгжлийн зөвлөл, <<https://bahrainedb.com/key-updates-on-covid-19/>> хандсан 2020.04.10

⁴³ Мөн тэнд.